



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

доод 10.13 № ХТ/2273  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг нэн яаралтай товлож өгөхийг хүсье.

Хавсралт<sup>506</sup>... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235022404



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

догс. 10. 41 № 1/5305

танай \_\_\_\_\_-ны № 01/2575 -Т

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА  
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

  
Б.ЭНХБАЯР

15160/471  
Doc.said.a5.2023



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn  
Вэбсайт:www.mof.gov.mn

2023.10.12 № 01/7538

танай 2023.10.11 -ны № 01/2878 -т

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
Х.БУЛГАНТУЯА ТАНАА**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002306

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

"ИХ.ХЭЛЭЛЦСЭН нь: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## **ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага байна.

#### **1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт "...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан.

Мөн Монгол Улс 1990 онд нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Арван есдүгээр зүйлийн 1-д "Оролцогч улсууд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна", 2-т "Хамгаалалтын ийм арга хэмжээ нь хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусламжийг үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, авч хэлэлцэхээр шилжүүлэх, мөрдөн байцаалт явуулах, эмчлэх, шаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг агуулна" гэж тус тус заасан.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулиараа болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах, эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийн дагуу 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийг 2016 онд хүчингүй болгож, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг тус тус шинээр батлан мөрдөж байна.

Өнгөрсөн хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуульд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Соёлын тухай хууль болон салбар дундын харилцааг зохицуулах бусад хуулийн шинэчлэлийг дагалдан 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Тухайлбал, 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хамтарсан багийн чиг үүрэгтэй холбоотой заалтуудыг Хүүхэд хамгааллын тухай хуулиас хасаж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд оруулсан.

2018 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга болон аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтсийн даргыг томилох, чөлөөлөх заалтыг нэмж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болохыг тодорхойлсон. Мөн 2019 онд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2021 онд Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой Хүүхэд хамгааллын тухай хуульд олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалахтай холбоотой тодорхой заалт бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

2017 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос “Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 5 дугаар тайлан”-д өгсөн дүгнэлт, зөвлөмжөөр Хүүхэд хамгааллын тухай хуулийг Хүүхдийн эрхийн тухай конвенцод нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх, шаардлагатай бүх арга хэмжээг авах, ялангуяа шаардлагатай санхүү, хүний нөөцийг хангалттай хуваарилахад илүү анхаарахыг зөвлөсөн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”<sup>1</sup>-ын 2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”<sup>2</sup>-ны 2.3.2-т “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана” гэж тусгасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”<sup>3</sup>-ийн 2.5.8-д “Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэж, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”<sup>4</sup>-д “Хүүхэд хамгааллын тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах, уг хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх зүйн үндсийг бий болгох, хүүхдийн эрхийг

<sup>1</sup> <https://legalinfo.mn/mn/detail/15406>

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail/15406>

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail/15586>

<sup>4</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16147375266521>

хамгаалахад эцэг, эх, олон нийт, байгууллага, хуулийн этгээдийн үүргийг нарийвчлан тусгах, түүнчлэн хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээний төрлийг тодорхой болгох, үйлчилгээг хүргэх үйл явц, хяналт, хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг давтан сургах, эрх олгох, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах” гэж тусгасан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенцоор хүлээсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах, түүнийг зөрчихтэй тэмцэх төрийн үүрэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмж болон дээр дурдсан бодлогын баримт бичгийн хүрээнд хүүхдийг нийгмийн бүх орчинд зүй бус хандлага, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдал, ялгаварлан гадуурхал, дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгод нийцүүлэн шинэчилнэ.

## **1.2.Практик үндэслэл, шаардлага**

Монгол Улсын хүн амын 36.2 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаагаас хагас өнчин хүүхэд 36363, бүтэн өнчин хүүхэд 2911, үрчлэгдсэн хүүхэд 1478, хүнсний эрхийн бичигт хамрагддаг хүүхэд 76063<sup>5</sup>, нийгмийн халамжийн зайлшгүй дэмжлэг тусалцаа шаардлагатай өрхөд амьдарч байгаа 460344<sup>6</sup>, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд 14207, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхэд 3226, асрамж халамжийн 30 төвд 1031 хүүхэд амьдарч байна<sup>7</sup>. 2022 оны жилийн эцсийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн нийт 111776 дуудлагаас зорилтот дуудлага 64811, хүүхэд хамгааллын кейсийн тоо 9 224 байна<sup>8</sup>.

Мөн хүүхэд оролцсон гэмт хэрэг 1540, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 2014, гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд 92, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 177, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 358 хүүхэд байсан ба бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн 70 орчим хувь нь гэр бүлийн орчинд ураг төрлийн хүрээнд хүчирхийлэлд өртсөн байна<sup>9</sup>.

Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүүхдийн хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 6.4 тэрбум төгрөг, 2021 онд 8.0 тэрбум төгрөг, 2022 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч 8 дахин нэмэгдсэн байна.

Хэдийгээр хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн боловч хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн гүйцэд, тасралтгүй, тогтвортой хүргэж чадахгүй, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь тодорхойлж, төлөвлөж, хүргэж, үнэлж,

<sup>5</sup> ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан. 2022 он

<sup>6</sup> ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан. 2022 он

<sup>7</sup> ГБХЗХГ-ын мэдээллийн сан. 2022 он

<sup>8</sup> ГБХЗХГ-ын мэдээллийн сан. 2022 он

<sup>9</sup> Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн танилцуулга, ЦЕГ. 2022 он

хянаж, санхүүжүүлээгүй<sup>10</sup>, хүүхэд хамгааллын үйлчилгээ, түүний дотор хамтарсан багийн үйлчилгээнд зардал хуваарилагдахгүй байгаа нь үйлчилгээний түвшин, хэлбэр, үйлчилгээг хүргэх үйл явц, нэр төрөл, зардал тооцох аргачлал тодорхой бус, нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах шат, шатны төрийн байгууллагын чиг үүрэг тодорхой бус байгаатай холбоотой.

Хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээ нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд болон төвлөрсөн асрамж, түр хамгаалах байр зэрэг институтчилэгдсэн хэлбэрт төвлөрч, эрсдэлт нөхцөлд байгаа болон алслагдсан орон нутгийн, Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, харьяат бус хүүхдэд хүртээмжгүй, мөн асралт гэр бүлтэй адил удаан хугацаанд гэр бүлд тулгуурласан, гэр бүлтэй адилтгах орчинд нь дэмжин хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ дутагдалтай, кейсийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийхээс кейсийг хаах хүртэл дараагийн шатны хамгааллын нийгмийн ажил үйлчилгээ бүрэн хийгдэхгүй байна.

Иймд хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын үр өгөөж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хамгаалал шаардлагатай хүүхэд бүрд хүрч үйлчлэхийн тулд хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хэлбэр, үйлчилгээг хүргэх үйл явц, нэр төрлийг тодорхой болгох, төсвийн хуваарилалтыг үйл ажиллагаа, үр дүнгийн үзүүлэлт, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо, хүн амын тоо зэрэг статистик мэдээлэлд тулгуурлаж хийх, санхүүгийн зарцуулалт, аргачлал, хяналтыг сайжруулах зэрэг хууль, эрх зүйн шинэчлэлийг цогцоор нь хийх шаардлагатай байна.

Хуульд хамтарсан багийн хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах чиг үүргийг оруулах, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагатай хэрхэн ажиллах, хүүхэд хамгааллын тохиолдлыг мэдээлэх, холбон зуучлах үйлчилгээний зохицуулалт, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага ба менежментийн дэмжлэгийг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сантай хамтран хийсэн Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд онцлон тэмдэглэсэн.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон олон улсын бусад сайн туршлагад нийцэж байгаа эсэхийг судалсан дүн шинжилгээгээр хүүхдийн эрхэд суурилсан хандлагад нийцсэн үг хэллэгийг тууштай хэрэглээгүй, хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзан үзэх зарчмыг бүрэн тусгаагүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхдэд хамааралтай аливаа шийдвэр гаргахад хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх асуудлыг тусгаагүй, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зааж өгөөгүй байна хэмээн дүгнэсэн.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, тэдгээрийн үзэл баримтлалд нийцүүлэх, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолтыг өргөжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэр

---

<sup>10</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ: Монгол Улс, НҮБ-ын Хүүхдийн Сан, Корам Интернейшнл. 2021 он

төрөл, хүргэх үйл явц, үүрэг хүлээгч, оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгох, хамтарсан багийн үйл ажиллагааг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд рүү чиглүүлж өргөжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх зүйн үндсийг бий болгох шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, батлуулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

### **Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол” гэж заасны дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

**Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт** Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенцын үзэл санаа, зарчимд нийцүүлэн хуулийн зорилт, хүүхэд хамгааллын зарчим, нэр томъёог тодорхойлж, хуулийн үйлчлэлийн хамрах хүрээг өргөжүүлнэ.

Тухайлбал, хуулийн үйлчлэлд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын болон харьяалалгүй хүний хүүхэд хамрагдах, хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн тодорхойлох, хүүхэд хамгааллын зарчмуудыг Хүүхдийн эрхийн конвенцод нийцүүлнэ.

**Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт** Хүүхэд хамгааллын тогтолцоог тодорхойлж, хүүхэд хамгааллын бодлого зохицуулалт, хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлно.

Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээг анхан шатанд үзүүлэх хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

**Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт** Гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын зохицуулалт, сүм, хийдийн дэргэдэх сургуульд сурч байгаа болон үйлчлүүлж буй хүүхдийн хамгааллыг тусгаж, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, салбаруудаас үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээ болон мэдээллийн сангийн бүрдүүлэлт, зохицуулалтыг тогтоож, хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэгч, оролцогч талуудын эрх, үүргийг заана.

**Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт** Хүүхэд хамгааллын үйлчилгээг шинээр томъёолж, кейс менежмент буюу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлыг мэргэжлийн удирдлага, нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сүлжээ, хяналт, хариуцлагын тогтолцооны хүрээнд явуулах зохицуулалтыг тусгана.

Хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах шуурхай тусламжийн үйлчилгээ, хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлын улмаас үүссэн бие махбод, сэтгэл санаанд үүссэн үр дагаврыг арилгах саармагжуулах, хүүхдийг хэвийн амьдралд ороход нь туслах, гэр бүлийн орчинд болон гэр бүлээс тусад нь хамгаалах, нөхөн

сэргээх үйлчилгээ, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилтот болон зорилтот бус олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн гурван түвшний цогц үйлчилгээг үе шаттайгаар хүүхэд, гэр бүлд мэргэжлийн түвшинд төр, иргэний нийгмийн түншлэл, мэргэшсэн төрийн бус байгууллагаар хамтран үзүүлэхээр тодорхойлно.

**Хуулийн төслийн Тавдугаар бүлэгт** хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлыг мэргэжлийн удирдлага, нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сүлжээ, хяналт, хариуцлагын тогтолцооны хүрээнд явуулах зохицуулалтыг тусгана. Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага, түүний үйл явцыг дэлгэрүүлэн тодорхой болгож, тохиолдолд суурилсан менежментийг нэвтрүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгана.

**Хуулийн төслийн Зургадугаар бүлэгт** Хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг тусгана.

**Хуулийн төслийн Долдугаар бүлэгт** Хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага болон хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг заана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар хүүхдийг асран хамгаалах, сайн сайхан байдлыг хангах эцэг, эх, гэр бүл, асран хамгаалагч, төрийн болон бусад оролцогч талуудын үүргийг баталгаажуулна.

Хүүхэд нь тусгай эрх болон хамгаалалт шаардлагатай эрх эдлэгчийн хувьд түүний эрхийг баталгаажуулсан хууль байна.

Хүүхэд хамгаалах төрийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг бүх түвшинд тодорхойлогдож, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд, шаардлагатай хүүхэд бүрд хүртээмжтэй хүргэх болно.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх түвшин, үйл явц, хэлбэрүүдийг тодорхойлж, салбаруудад хүүхэд хамгааллын төсөв хуваарилагдаж, хүүхэд хамгаалалд зориулсан төсвийн үр ашиг, өгөөж сайжирч, хамгаалал шаардлагатай хүүхэд бүрд чанартай цогц үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн төрийн бус байгууллагаар хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээг анхан, дунд шатанд, шаардлагатай хүүхэд, гэр бүлд хүргэх, санхүүжилт, хяналт, хариуцлагын эрх зүйн үндэслэлүүд бий болно.

Нийгмийн бусад салбаруудад хүүхэд хамгааллын бодлоготой байхыг хуульчилж өгснөөр хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих олон нийт, нийгмийн хандлагыг бий болгоно.

Хэдийгээр тус хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс гарах зардал цаашид нэмэгдэх боловч хуулийг хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад хамгийн чухал нөлөө, үр дүнг үзүүлэх болно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох хуулийн талаар холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийг дагалдан Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Нийгмийн халамжийн тухай, Гэр бүлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүл мэндийн тухай, Хууль зүйн туслалцааны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Онц байдлын тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль болон бусад хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хууль хүчингүй болгох тухай болон бусад холбогдох шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулна.

# ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*Хүүхэд хамгааллын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төслийн тухай*

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д "Хүүхэд хамгааллын тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах, уг хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх зүйн үндсийг бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг, эх, олон нийт, байгууллага, хуулийн этгээдийн үүргийг нарийвчлан тусгах, түүнчлэн хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээний төрлийг тодорхой болгох, үйлчилгээг хүргэх үйл явц, хяналт, хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг давтан сургах, лицензжүүлэх, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах"-аар тусгасан нь тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болов.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр Хүүхэд хамгааллын тухай хуулийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенц болон олон улсын бусад сайн туршлагад нийцэж байгаа эсэхийг судалсан дүн шинжилгээгээр хүүхдийн эрхэд суурилсан хандлагад нийцсэн үг хэллэгийг тууштай хэрэглээгүй, хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзан үзэх зарчмыг бүрэн тусгаагүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхдэд хамааралтай аливаа шийдвэр гаргахад хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх асуудлыг тусгаагүй, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зааж өгөөгүй байна хэмээн дүгнэсэн.

Монгол Улсын хүүхдүүд тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлэх олон асуудалтай тулгарч байна. Хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүрээнд гарах хүчирхийллийн түвшин өндөр байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас хамтарсан багийн тухай заалтыг авч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд шилжүүлсэн нь:

Хамтарсан багийн үүргийг өөрчилж, өргөжүүлсэн нь хүүхэд хамгааллын хариу арга хэмжээтэй холбоотой манлайлал, удирдлага зохион байгуулалтын дэмжлэг, санхүүгийн хуваарилалт, хариуцлагыг сулруулж, ухраасан;

Нийгмийн ажлын чадавх сул, мэргэжлийн удирдлага хангалтгүй;

Кейс менежментийн арга зүйг тодорхой болгоогүй;

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, авах хариу арга хэмжээ, үйлчилгээ хөгжөөгүй, үйлчилгээний зураглал тодорхойгүй;

Хүүхдийн оролцоог тусгаагүй, хязгаарлагдмал;

Хүний нөөц, санхүүгийн нөөц дутагдалтай.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийг багтаасан хүүхэд хамгааллын дижитал мэдээллийн удирдлагын систем хөгжөөгүй хэмээн дүгнэсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Уг хууль батлагдсанаас хойш нийт 6 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 10 орчим зүйл, заалтад өөрчлөлт орсон.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 6 бүлэг, 25 зүйлтэй байсныг 7 бүлэг, 2 дэд бүлэг, 58 зүйл болгон баяжуулж, баталсан үзэл баримтлалын дагуу боловсруулсан. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Монгол Улсын хүн ам 3.4 сая болж өмнөх оноос 1.4 хувиар өсөж, нийт хүн амд 18 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь 36.2 буюу 1.252.049 хүүхэд байна<sup>1</sup>. Монгол Улсад 2022 оны байдлаар 941,5 мянган өрх бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар өссөн.

Хагас өнчин хүүхэд 36,3 мянга, бүтэн өнчин хүүхэд 2911, үрчлэгдсэн хүүхэд 1478, хүнсний эрхийн бичигт хамрагддаг хүүхэд 76063<sup>2</sup>, нийгмийн халамжийн зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхөд амьдарч байгаа 460344<sup>3</sup>, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд 14207, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхэд 3226, асрамж халамжийн 30 төвд 1031 хүүхэд амьдарч байна<sup>4</sup>. 2022 оны жилийн эцсийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн нийт 111776 дуудлагаас зорилтот дуудлага 64811, хүүхэд хамгааллын кейсийн тоо 9 224 байна<sup>5</sup>.

Мөн хүүхэд оролцсон гэмт хэрэг 1540, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 2014, гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд 92, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 177, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 358 хүүхэд байсан ба бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн 70 орчим хувь нь гэр бүлийн орчинд ураг төрлийн хүрээнд хүчирхийлэлд өртсөн байна<sup>6</sup>.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2018-2023 онд 19231 үйлчлүүлсний 67,7% нь хүүхэд, 32,3%-ийг насанд хүрэгч эзэлж байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүүхдийн хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 6.4 тэрбум төгрөг, 2021 онд 8.0 тэрбум төгрөг, 2022 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч 8 дахин нэмэгдсэн байна.

Хэдийгээр хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн боловч хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн гүйцэд, тасралтгүй, тогтвортой хүргэж чадахгүй, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь тодорхойлж, төлөвлөж, хүргэж, үнэлж, хянаж, санхүүжүүлж чадахгүй<sup>7</sup>, хүүхэд хамгааллын үйлчилгээ, түүний дотор Хамтарсан багийн үйлчилгээнд зардал хуваарилагдахгүй байгаа нь үйлчилгээний түвшин хэлбэр, үйлчилгээг хүргэх үйл явц, нэр төрөл, зардал тооцох аргачлал тодорхой бус, нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх,

<sup>1</sup> УСХ., [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>2</sup> ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан. 2022 он

<sup>3</sup> ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан. 2022 он

<sup>4</sup> ГБХЗХГ-ын мэдээллийн сан. 2022 он

<sup>5</sup> ГБХЗХГ-ын мэдээллийн сан. 2022 он

<sup>6</sup> Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн танилцуулга, ЦЕГ. 2022 он

<sup>7</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ. Монгол Улс, НҮБ-ын Хүүхдийн Сан, Корам Интернейшнл. 2021 он

мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах шат шатны төрийн байгууллагын чиг үүрэг нарийн тодорхой бус байгаатай холбоотой.

Хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээ нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд болон төвлөрсөн асрамж, түр хамгаалах байр зэрэг институтчилэгдсэн хэлбэрт төвлөрч, эрсдэлт нөхцөлд байгаа болон алслагдсан орон нутгийн, Монгол Улсын хилийн гадна байгаа хүүхэд, харьяат бус хүүхдэд хүртээмжгүй, мөн асралт гэр бүлтэй адил удаан хугацаанд гэр бүлд тулгуурласан, гэр бүлтэй адилтгах орчинд нь дэмжин хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ дутагдалтай, кейсийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийхээс кейсийг хаах хүртэл дараагийн шатны нийгмийн ажил үйлчилгээ бүрэн хийгдэхгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, тэдгээрийн үзэл баримтлалд нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэр төрөл, хүргэх үйл явц, үүрэг хүлээгч, оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгох, Хамтарсан багийн үйл ажиллагааг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд рүү чиглүүлж өргөжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хуулийн давхардал, хийдлийг арилгаж, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн үндсийг бий болгохыг зорьж байна.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн бүх шатны байгууллага, хүн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоотой уяж, Засгийн газар, хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйлчилгээний хэлбэр, санхүүжилт, хяналт, олон нийтийн оролцоог шинээр тодорхойллоо.

*Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт* Хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түр болон байнга оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хууль үйлчлэхээр тодорхой тусгав. Мөн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу 18 насанд хүрсэн хүнд өөрийнх нь зөвшөөрснөөр 21 нас хүртэл нь хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх зохицуулалт тусгав.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хууль тогтоомж, зарчим, нэр томъёоны тодорхойлолтыг нэмж боловсруулав.

*Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт* Хүүхдийн эрхийн тухай Нэгдсэн үндэсний байгууллагын конвенц, Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлж, Засгийн газар, хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг шинээр тодорхойлсон.

Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, нийгмийн ажилтан, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүргийг хуульд шинээр нэмж тусгаад байна.

Сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд нэмж, нийгмийн ажилтны үүргийг заав.

Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хүүхэд хамгааллын цахим хувийн хэрэг үүсгэж, ашиглах шинэ зохицуулалт нэмж орууллаа.

Барилга, байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч эсхүл хүүхдийн эрх, хамгааллын

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөлөл ажиллах эрх зүйн зохицуулалт оруулав.

*Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт* Гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах харилцаанд нэмж сургуулийн орчинд гардаг үе тэнгийнхний дээрэлхэлт (bullying), хурдан морины уралдаанч хүүхдийг хамгаалах, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын зохицуулалтыг шинээр тусгасан. Тухайлбал,

Гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл, мэдээлэл, цахим орчин, соёл, спортын арга хэмжээ, үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний үе дэх хүүхэд хамгааллыг өргөжүүлж,

-Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллыг шинээр нэмж тусган,

-Салбар бүр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам баталж, үйлчилгээнд шаардагдах санхүүжилтээ Засгийн газраас баталсан Хүүхэд хамгааллын үйлчилгээний аргачлал, нормативын дагуу төсөвлөн жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх шинэ зохицуулалтууд тусган. Тухайлбал,

Боловсрол, сургалтын байгууллага болон сургалтын бусад байгууллага, дотуур байр, сүм хийд, сүм хийдийн дэргэдэх дотуур байран дахь хүүхэд хамгааллыг тодорхойлж, боловсролын орчинд үе тэнгийнхний дээрэлхэлт, хүүхдийн эрхийн зөрчлийн мөрөөр авах арга хэмжээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх процессыг боловсронгуй болгосон.

*Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт* Хуульд хүүхэд хамгааллын тохиолдлыг мэдээлэх суваг, арга замуудын хооронд зохицуулалт, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага ба менежментийн дэмжлэгийг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтран хийсэн Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд онцлон тэмдэглэсэн.

Иймд Хүүхэд хамгааллын үйлчилгээг шинээр томьёолж, Хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ (гэр бүлд нь суурилсан, гэр бүлээс нь тусгайлан), урьдчилан сэргийлэх гэсэн гурван хэлбэрээр хүргэхээр заасан.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хянах, хаах кейс менежментийн 6 алхмыг тусгалаа.

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллага, олон нийт, сайн дурын ажилтны дэмжлэг, туслалцаа, хүүхдийн оролцоотойгоор зохион байгуулна.

*Хуулийн төслийн Тавдугаар бүлэгт* Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлагын хүрээнд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлийг тодорхойлсон. Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлага нь хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хүүхэд хамгааллын тодорхой кейстэй холбоотойгоор удирдан чиглүүлэх, сургах, дэмжин туслах, холбох хэлбэрээр хэрэгжихээр заав.

*Хуулийн төслийн Зургаадугаар бүлэгт* Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгах, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейст тулгуурлаж дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтоодог байх эрх зүйн зохицуулалттай болгож байна.

- Хүүхэд хамгааллын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, орон нутгийн төсөв, үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр, дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж гэсэн дөрвөн эх үүсвэртэй байхаар тодорхойллоо.

- Байгууллага, хуулийн этгээд нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулахаар шинээр тусгасан.

Салбар бүр Засгийн газраас баталсан хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын аргачлал, нормативын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлыг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх шинэ зохицуулалт оруулсан.

*Хуулийн төслийн Долоодугаар бүлэгт* гомдол, нэхэмжлэл гаргах харилцаа, шилжилтийн үеийн зохицуулалт, Хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага болон хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг заасан.

Хууль батлагдсанаар хүлээж буй үр дүн:

Хүүхэд хамгаалах төрийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг бүх түвшинд тодорхойлогдож, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд, шаардлагатай хүүхэд бүрд хүргэнэ. Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоо бэхэжнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, үйл явц, төрөл, хэлбэрүүдийг тодорхойлж, хүүхэд хамгаалалд зориулсан төсвийн үр ашиг, өгөөж сайжирч, хамгаалал шаардлагатай хүүхэд бүрд чанартай цогц үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын кейс менежментийн алхмуудыг тодорхойлж, мэргэжлийн удирдлагын чиг үүргийг хуульчилснаар хүүхдэд хамгааллын үйлчилгээг цаг алдалгүй, үр дүнтэй хүргэх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжих, үр дүнг үнэлэх, хянах механизм сайжирна.

Магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн төрийн бус байгууллагаар хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээг, анхан дунд шатанд, шаардлагатай хүүхэд, гэр бүлд хүргэх, санхүүжилт, хяналт, хариуцлагын эрх зүйн зохицуулалттай болно.

Сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай болсноор хууль тогтоомжийн хэрэгжилт анхан шатанд сайжирч, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

Салбар бүр хүүхэд хамгааллын бодлоготой байхыг хуульчилж өгснөөр хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага олон нийт, нийгмийн дунд бий болохоос хүүхдийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурч, хүүхдэд ээлтэй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хэдийгээр тус хуулийн дагуу улсын төсвөөс гарах зардал цаашид нэмэгдэх боловч хуулийг хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад хамгийн чухал нөлөө, үр дүнг үзүүлэх болно.

Хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг хийж, Засгийн газрын гишүүд, төрийн бүх шатны байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, их, дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаачид, 1300 гаруй хүүхдийн дунд хэлэлцүүлж, санал авсан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын холбооны Улс, Австралийн Холбооны Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, хүүхэд хамгааллын хууль тогтоомж, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хэлбэрүүд, эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, дэмжлэг зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой зохицуулалтыг энэ хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн авч тусгав.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ болон холбогдох бусад хууль, уг хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан бөгөөд төсөлтэй холбогдуулан Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

---oOo---

## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлал, Хуулийн тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлсэн боловсруулж, олон нийтээс ирүүлсэн санал, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган 7 бүлэг, 57 зүйлтэйгээр боловсруулав. Хууль тогтоомжийн тухай хуулийн §33.4-т “Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад шинэчилсэн найруулга бол бүлгээр, ... багцлан тусгана” гэж заасны дагуу танилцуулгыг доорх байдлаар боловсруулан бэлтгэв.

Бүлэг	Зүйл	Танилцуулга
<p><b>Нэгдүгээр бүлэг.</b> Нийтлэг Үндэслэл</p>	<p>1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго</p> <p>1.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж</p> <p>1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>1.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын зарчим</p>	<p>1. Одоо үйлчилж буй Хүүхэд хамгааллын тухай хуульд буй “хуулийн зорилт” гэснийг “Хуулийн зорилго” болгон өөрчилж, “хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино” гэж шинээр томъёолов.</p> <p>2.Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн бүрдлийг шинээр тусгав. Хүүхэд хамгаалал нь салбар дундын асуудал байдаг бөгөөд олон төрлийн хууль, дүрэм, журам хүүхэд хамгаалалд хамааралтай байдаг. Үүнийг харгалзан хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тогтоосон хуулийн хэм хэмжээ зөрчилдвөл хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэхээр заав.</p> <p>3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд “Хүүхэд хамгааллын тухай хууль нь 18-аас доош насны хүүхдэд хамааралтай бөгөөд зөвхөн Монгол Улсын харьяалалтай хүүхдэд уг хууль үйлчлэхээр заасан нь ХЭК-той зөрчилдөж байна. Өнгөц харвал энэ нь Монгол Улсад амьдарч буй иргэн бус хүүхдүүд хууль ёсоор болон хууль бусаар оршин сууж буй эсэхээс үл хамааран ямарваа хамгаалалтгүй үлдэнэ гэсэн үг юм” гэсэн байдаг. Иймд хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгож “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга болон түр оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарах”-аар тусгав.</p> <p>4.Хуулийн төслийн нэр томъёонд дараах зарчмын нэмэлт, өөрчлөлтийг бий болгосон. Үүнд: Хүүхдийн сайн сайхан байдал, Хүүхэд хамгаалал, Үе тэнгийн дээрэлхэлт, Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, Асралт гэр бүл, Кейс менежемент, Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага зэрэг нэр томъёог шинээр томъёолж оруулав. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд зэрэг нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөв. Дагаж мөрдөж буй хуульд буй “хууль зөрчсөн хүүхэд” гэсэн нэр томъёог</p>

		<p>өргөжүүлэн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж өргөжүүлэн томъёолж тодорхойлов.</p> <p>5. Хүүхэд хамгааллын асуудлаар бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, арга хэмжээ авахад нэг мөр хангах, баримтлах зарчмуудыг олон улсын нийтлэг жишигт тулгуурлан шинэчлэн тодорхойлж оруулав. Тодруулбал, хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах хамгийн тохиромжтой арга бол хүүхдийн гэр бүлийг дэмжих гэдгийг хүлээн зөвшөөрөх; хүүхдээ хамгаалах чадвартай, хүсэл эрмэлзэлтэй эцэг, эхгүй бол төр хүүхдийг хамгаалах; төр хүүхдийг хамгаалахдаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах; хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд нэн тэргүүнд төрөл, садны гэр бүлийн асрамжид байлгахыг эрмэлзэх; хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд хүүхдийг аль болох ах, эгч, дүүтэй нь хамт байлгах; хүүхдийг зөвхөн эцэг эх, эсхүл асран хүмүүжүүлэх чадвар, хүсэл эрмэлзэлтэй этгээдийн асрамжид өгөх зэрэг зарчмыг шинээр тусгав.</p>
<p><b>Хоёрдугаар бүлэг.</b> Хүүхэд хамгааллын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт</p>	<p>2.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын тогтолцоо</p> <p>2.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт</p> <p>2.3 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг</p> <p>2.4 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг</p> <p>2.5 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг</p> <p>2.6 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн</p>	<p>1. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэхээр тусгав. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэ заалтыг Хүүхэд хамгааллын тухай хуульд бататган зааж, “байгууллагын хүүхэд хамгааллын бодлого” гэдгийг хэрхэн ойлгох талаар зүйлийн доор тайлбар оруулсан.</p> <p>2. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт нь Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэх, хүүхдийг хамгаалах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээдийг энэ хуульд заасны дагуу оролцуулж болохоор тусгасан.</p> <p>3. Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу яам, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл,</p>

	<p>байгууллагын чиг үүрэг</p> <p>2.7 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан</p> <p>2.8 дугаар зүйл. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн чиг үүрэг</p> <p>2.9 дүгээр зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг</p> <p>2.10 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын чиг үүрэг</p> <p>2.11 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо</p> <p>2.12 дугаар зүйл. Хууль зүйн хорооны чиг үүрэг</p> <p>2.13 дугаар зүйл. Хууль зүйн хорооны хуралдаан, түүнээс гарах шийдвэр</p> <p>2.14 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар хууль зүйн хороонд мэдэгдэх үүрэг</p> <p>2.15 дугаар зүйл. Хамтарсан баг</p> <p>2.16 дугаар зүйл. Хамтарсан багийн чиг үүрэг</p>	<p>бүх шатны Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг нарийвчлан заав.</p> <p>4. Анхан шатны нэгжид буюу гэр бүл, хүүхдэд хүрч ажиллах хүний нөөц байхгүй байгааг засах зорилгоор сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар заав. Ингэхдээ хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батдах, тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батлах” зохицуулалтыг тусгав. Мөн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны эдлэх эрх, хүлээх үүргийг нарийвчлан тусгав.</p> <p>5. НҮБ-ын Хүүхдийн сангийн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны талаар анх удаа хуульчилсан байдаг. Уг хорооны ажиллах журмыг хуулиар биш хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмаар зохицуулахаар заасан байна. Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны ажил хангалтгүй, хорооны гишүүд ирц, идэвх сул байгаа зэрэг нийтлэг дутагдал байгаа талаар судалгааны тайлангуудад дурдагдсан байдаг. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хүүхэд хамгааллын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдэд ээлтэй явуулахад чухал бүтэц болно. Иймд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хэрхэн байгуулах, ямар чиг үүргийг хэрэгжүүлэх, уг хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт зэргийг журмаар биш хуулиар зохицуулах шаардлагатай гэж энэ талаарх зохицуулалтыг төсөлд тусгав. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь үйл ажиллагаагаа явуулахын тулд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд”-ийн мэдээллийг холбогдох субъектүүдээс авдаг байх шаардлагатай. Иймд хуулийн төсөлд эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг харьяа Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албанд явуулдаг байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p> <p>6. Хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд</p>
--	--	--

	<p>2.17 дугаар зүйл. Хамтарсан багийн зохион байгуулалт</p> <p>2.18 дугаар зүйл. Хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын оролцоо</p>	<p>туслахыг үүрэгжүүлсэн зохицуулалтыг тусгав. Хамтарсан багийн гишүүн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх явцад хамтарсан багтай хамтран ажиллаж байгаа хүн, хуулийн этгээд нь хүүхдийн мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд тэднээс нууц хамгаалах баталгааг бичгээр авахаар тусгасан. Хамтарсан багийн чиг үүргийг хуульд шинээр оруулахаар заав.</p> <p>7. Хүүхэд хамгааллын үйлчилгээг тухайн чиглэлээр мэргэшсэн хүн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээдийн мэдээллийн санг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэж, хөтөлнө. Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хүн, хуулийн этгээд гэрээний үүргээ удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн, хүчирхийлэл үйлдсэнийг шүүх, хүүхдийн эрхийн улсын байцаагч, бусад эрх бүхий албан тушаалтан тогтоосон тохиолдолд тухайн этгээдийг хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулдаг байх зохицуулалтыг тусгав.</p>
<p><b>Гуравдугаар бүлэг.</b> Гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгаалал</p>	<p>3.1 дүгээр зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал</p> <p>3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал</p> <p>3.3 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал</p> <p>3.4 дүгээр зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал</p> <p>3.5 дугаар зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал</p> <p>3.6 дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал</p>	<p>1. Салбар бүр хүүхэд хамгааллын бодлого, журмыг батлах, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг өөрийн төсөвтөө тусгаж байхаар тусгав. Ингэснээр хүүхэд хамгаалал нь төсвийн хомсдолоос гарахад эергээр нөлөөлнө гэж үзэж байна.</p> <p>2. Эцэг, эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх, хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эрхийн үйлдвэрлэл, үйлчилгээндээ ажиллуулах, хүүхдийнхээ эрх, нэр төрд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зургийг бусдад дамжуулах, цахим орчинд байршуулахыг хориглохоор тусгав. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эрх бүхий байгууллагаас зохион байгуулах хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын сургалтад хамрагдаж тодорхойлолт авсны үндсэн дээр Нийгмийн халамжийн тухай хууль болон Эх, эцэг, олон хүүхэдтэй ерх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн заасан тэтгэмжид хамрагдах заалтыг тусгав.</p> <p>3. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал дээр “үе тэнгийн дээрэлхэлт”-ийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, тодруулбал, хохирогч хүүхэд болон үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн суралцагчид ямар арга хэмжээ авахыг журамлан заасан. Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллага, сүм, хийд, түүний дэргэдэх шашны сургуульд суралцаж байгаа хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг тусгав.</p>

	<p>3.7 дугаар зүйл. Гамшиг, онцгой байдлын нөхцөл дэх хүүхэд хамгаалал</p> <p>3.8 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал</p>	<p>4. Эрүүл мэндийн байгууллага хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээг гэр бүлийн хүчирхийллийн болон гэмт хэргийн хохирогч хүүхдэд харьяалал, дараалал харгалзахгүйгээр шууд үзүүлэх шинэ зохицуулалтыг тусгав.</p> <p>5. Цахим орчин болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх хориотой, хортой контент, бүтээл, мэдээ, мэдээллээс хамгаалах орон тооны бус дэд зөвлөл Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дэргэд ажиллахаар тусгав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хориотой, хортой контент, бүтээлийг таних, хязгаарлах, хаах арга хэмжээг авахыг үүрэгжүүлэв. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хориотой, хортой контентыг хязгаарлах, контентын ангиллын тэмдэглэгээг олон нийтэд түгээхийн өмнө байршуулах, насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх боломжоор хэрэглэгчийг хангасан байна.</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч, олон нийтийн сүлжээг хэрэглэгч нь хүүхдийг гүтгэсэн, заналхийлсэн, хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн хувийн мэдээллийг агуулсан контент, мэдээ, мэдээллийг бүтээх, нийтлэх, түгээхийг хориглохоор тусгав. Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээг дэмжих, цахим орчинд хүүхдэд учрах нийтлэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгав.</p> <p>6. Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээнд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага хяналт тавина.</p> <p>7. Хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг шинээр тусгав.</p> <p>8. Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалтаас өөрчлөгдөж байгаа зүйл нь энэ бүлэгт шинээр “Гамшиг, онцгой байдлын нөхцөл дэх хүүхэд хамгаалал, Хэрэг</p>
--	---	--

		<p>хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал” гэсэн хоёр шинэ зүйлийг нэмсэн.</p> <p>9.Хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах, хүүхдийн биед үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон таатай орчинд гүйцэтгэхээр тусгав. Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх нь хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авахын өмнө хүүхдийг мэдээллээр хангах үүргийг тусгав. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулахаар тусгав. Ингэснээр энэ чиглэлийн мэргэшсэн мэргэжилтэн буюу шинжээчийг бий болгох боломж бүрдэнэ гэж үзэж байна.</p>
<p><b>Дөрөвдүгээр бүлэг.</b> Хүүхэд хамгааллын үйлчилгээ</p>	<p>4.1 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр</p> <p>4.2 дугаар зүйл. Шуурхай тусламжийн үйлчилгээ</p> <p>4.3 дугаар зүйл. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ</p> <p>4.4 дүгээр зүйл. Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх</p> <p>4.5 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэл</p> <p>4.6 дугаар зүйл. Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах</p> <p>4.7 дугаар зүйл. Хүүхдийг асралт гэр бүлд асруулах</p>	<p>1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь шуурхай тусламжийн үйлчилгээ; хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ; урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн гурван хэлбэртэй байна.</p> <p>2. Шуурхайн тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон буюу хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн, хүүхдийн зан байдал нь өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар нөхцөл байдалд орсон хүүхдийн амь нас, эрүүл мэндийг яаралтай хамгаалах арга хэмжээ авах журмыг тодорхой тусгав.</p> <p>3. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ гэр бүлийн орчинд болон гэр бүлээс нь тусдаа орчинд гэсэн хэлбэрээр үзүүлнэ. Гэр бүлийн орчинд гэдэг нь хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлахгүйгээр хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн тусламж үйлчилгээг үзүүлэхийг ойлгоно.</p> <p>4. Хэрэв хүүхдийг гэр бүлийн орчинд байлгах нь хүүхдэд аюултай, түүнд хор хохирол учруулах байгаа тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласны үндсэн дээр хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд юун түрүүнд хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах, уг арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд хүүхдийг асралт гэр бүлд (foster family) асруулах, эдгээр хоёр арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд эцэст нь хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах арга хэмжээг тусгав.</p> <p>Асралт гэр бүл хүүхдийг тодорхой хугацаанд асран халамжилж байгаа хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн хүүхдийн төрөл, садны биш гэр бүлийг ойлгох тул хүүхдийн төрөл, садны гэр бүлтэй хутган ойлгож болохгүй. Хүүхдийг төрөл, садны гэр бүл болон асралт гэр бүлд</p>

<p>4.8 дугаар зүйл. Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах</p> <p>4.9 дүгээр зүйл. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ</p> <p>I дэд бүлэг Кейс менежмент</p> <p>4.10 дугаар зүйл. Кейс менежментийн үе шат</p> <p>4.11 дүгээр зүйл. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх</p> <p>4.12 дугаар зүйл. Мэдээлэл өгөгчийг нууцлах</p> <p>4.13 дугаар зүйл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө гаргах</p> <p>4.14 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, зохицуулах</p> <p>4.15 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх</p> <p>4.16 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын кейсийг хаах</p>	<p>асруулахаас өмнө тухай гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийсэн байх ёстой. Мөн асралт гэр бүлийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй шууд адилтган ойлгож болохгүй. Асралт гэр бүл нь тодорхой хугацаанд хүүхдийг асран хүмүүжүүлдэг бол асран хамгаалагч, харгалзан дэмжигч дээр тодорхой хугацаа байдаггүй. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эцэг, эхийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээдэг бол асралт гэр бүл нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй харьцуулахад эдлэх эрх, үүрэг нь хязгаарлагдмал байна. Эд хөрөнгө, санхүү, эрүүл мэндийн байдал болон хүүхдийг асран хүмүүжүүлэх чадваргүй, хүсэл эрмэлзэлгүй гэр бүлд хүүхдийг өгч болохгүй.</p> <p>5. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах нь хүүхдийн болоод эцэг, эрхийн эрхэд шууд нөлөөлөх шийдвэр байдаг тул хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэлийг хуульд нэг бүрчлэн заав.</p> <p>6. Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх кейс менежментийн үе шатыг хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх субъект нь ямар ажил, үйлчилгээ явуулах нь тодорхой болж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үр дүнтэй байхад эергээр нөлөөлнө гэж үзэж байна.</p> <p>7. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулдаг байх баталгааг төсөлд тусгав. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын кейсийг нээхээс хаах хүртэлх хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд хийгдсэн бүх шийдвэр, үйл ажиллагааг холбогдох стандарт, маягт, зааврын дагуу заасан хугацаанд баримтжуулж, биет болон цахим хэлбэрээр хадгалж, мэдээллийн санд оруулахаар тусгав.</p> <p>8. Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдийн тухайн оршин байгаа газрын хамтарсан баг, хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага үзүүлнэ. Хүүхэд хамгааллын кейсийг шийдвэрлэх явцад хүүхдийн оршин байгаа газар өөрчлөгдсөн тохиолдолд хүүхэд хамгааллын кейсийг харьяаллын дагуу хамтарсан баг, хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага руу шилжүүлнэ.</p> <p>9. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээдийн хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах баталгааг тусгав. Мөн хүүхэд өөрөө тусламж авахаар хандсан бөгөөд ийнхүү хандсан тухай мэдээллийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх нь хүүхдийн эрх, хууль</p>
---	---

		<p>ёсны ашиг сонирхолд хор хохирол учруулж болзошгүй тохиолдолд мэдээллийг нууцлахаар тусгав.</p> <p>10. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг хүлээн авч, түүний болон гэр бүл, сургалтын орчин зэргийг иж бүрнээр нь хамруулсан нөхцөл байдлын үнэлгээ хийх зохицуулалтыг тусгав. Энэхүү нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг гаргахаар тусгав.</p> <p>11. Тухайн хүүхдэд үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээг дуусгавар болгох үндэслэлийг тодорхой тусгасан. Хүүхэд хамгааллын кейсийг хаахад харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад танилцуулж, зөвшөөрөл авна. Ингэснээр хүүхэд хамгааллын үйлчилгээ үр дүнтэй байх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үр дүнд хүүхдийн сайн сайхан байдал хангагдах баталгааг нэмэгдүүлнэ.</p>
<p><b>Тавдугаар бүлэг.</b> Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага</p>	<p>5.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага, түүний хэлбэр</p> <p>5.2 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа</p> <p>5.3 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа</p>	<p>1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагаас хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага буюу "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажлын мэргэжилтнийг онол, арга зүйн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагаа"-г хэрэгжүүлэхээр тусгав.</p> <p>2. Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг 1) удирдан чиглүүлэх, 2) дэмжих, 3) зөвлөн туслах, 4) хөгжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.</p> <p>3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарч буй алдаа дутагдал, бэрхшээлийг тухай бүр тодорхойлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор нэгдсэн зөвлөмж, аргачлал, зааврыг боловсруулж, мөрдүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, хүүхэд хамгааллын кейсээс түүвэрлэн хянаж, нийтлэг гарч байгаа алдаа, дутагдлыг тогтоож, зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах; ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, зөвлөмж, зөвлөгөө өгөх зэргээр мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</p> <p>4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын кейс бүрийн материалтай танилцаж, алдаа, дутагдлыг арилгах арга хэмжээ авах, хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хийгдэж байгаа ажиллагаа, баримтжуулалтад хяналт тавих; хүүхэд хамгааллын кейсийн статистик мэдээ, кейс шийдвэрлэлтэд үндэслэн хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдэд зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах; хамтарсан уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлаар ярилцлага хийх, чиглэл,</p>

		<p>зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх зэргээр мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</p> <p>5. Арав хүртэлх нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг ахлах нийгмийн ажилтан, тав хүртэлх ахлах нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг зөвлөх нийгмийн ажилтан ажиллахаар тооцож зохион байгуулалт хийнэ.</p>
<p><b>Зургаадугаар бүлэг.</b> Хүүхэд хамгааллын санхүүжилт хяна</p>	<p>6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт</p> <p>6.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хяналт-шинжилгээ, үнэлгээ</p> <p>6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт</p> <p>6.4 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын захиргааны хяналт</p>	<p>1. Хүүхэд улсын төсөв; орон нутгийн төсөв; үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр; дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж зэрэг эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгав. Хүүхэд хамгааллын санхүүжилтийг энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p> <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.5.5-д зааснаар “хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ” нь нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгэх төрийн чиг үүрэг байх, мөн хуулийн 27.2-т “нэгжийн удирдлагад төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэнэ” гэж заасан.</p> <p>Иймд хүүхэд хамгаалалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төрөөс шийдвэрлэж байхаар байна. Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтоодог байх журмыг тусгав. Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар батална.</p> <p>2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</p> <p>3. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөөр удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан энэ хууль</p>

		<p>болон бусад холбогдох хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.</p> <p>4. Хүүхэд хамгааллын захиргааны хяналтыг хүүхдийн эрхийн улсын байцаагч хэрэгжүүлэхээр тусгав.</p>
<p><b>Долоодугаар бүлэг.</b> Бусад зүйл</p>	<p>7.1. дүгээр зүйл. Гомдол, нэхэмжлэл гаргах 7.2 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 7.3 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт 7.4 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</p>	<p>1. Энэ хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын асуудлаар гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчсөн гэж үзвэл Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу<sup>1</sup> гомдол, нэхэмжлэл гаргаж болохоор тусгав.</p> <p>2. Энэ хуулийг зөрчсөн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх, энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгав.</p> <p>3. Хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 1-д “Нийгмийн ажилтны мэргэжлээр дээд боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан хүнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна” гэж тусгасан. Гэвч одоо ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ажил үүргийг хавсран гүйцэтгэж албан хаагчид бүгд энэ шаардлагыг хангахгүй байдаг. Иймд энэ хууль батлагдахаас өмнө томилогдон ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн ажилтанд уг шаардлага хамаарахгүй байхаар хуулийн төсөлд шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгав. Мөн хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу тогтоосон орон тоогоор сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулахаар тусгасан.</p>

<sup>1</sup> Хүүхдийн эрхийн тухай хууль. §19.1.Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана. §19.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, сум, баг, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно.

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭСЭГ, ЗААЛТ ТУС БҮРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР ТАНИЛЦУУЛГА**

**Нэг. Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p><b>4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим</b>                      4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараах зарчмыг баримтална:</p>	<p>“4.1.6.хүүхдийг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжих боломжийг хангах;”                      “4.1.7.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх;”                      “4.1.8.хүүхдийн эрхийг хангахад оролцогч бүх талууд үйл ажиллагаандаа хуульд заасан төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх.”</p>	<p>Заалт нэмэх</p>
<p><b>6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх</b>                      6.1.Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараах эрх эдэлнэ:</p>	<p>“6.1.7.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах.”</p>	<p>Заалт нэмэх</p>
	<p>“6.3.Хүүхдийг гэр бүлийн орчинд бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжүүлэх үүргийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүлээнэ.                      6.4.Эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг болон нийгмийн бусад үйлчилгээ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна.                      6.5.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана.”</p>	<p>Хэсэг нэмэх</p>

**Тайлбар:**

Хүүхдийн хөгжлийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн ахиц дэвшлийг хамарсан байх ба энэ тасралтгүй явагдаж байж хүүхдийн хөгжих эрх хангагдах ёстой. Хүүхдийн хөгжих эрхийг хангахад төрөөс үзүүлэх үйлчилгээг “хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ” хэмээн шинээр томъёолж байгаа ба уг үйлчилгээг 1) хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, түвшнийг тодорхойлох, 2) хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөх, 3) хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэх, 4) үйлчилгээг төгсгөх, үнэлэх гэсэн 4 үе шатаар хэрэгжүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр

бүлээсээ тусгаарлагдан бусдын асрамж, халамжид байгаа хүүхэд, бага орлоготой өрхийн хүүхэд, үндэсний болон хэлний цөөнхийн хүүхэд, малчин өрхийн хүүхэд, сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдэд гэр бүлийн орчинд нь болон гэр бүлээс нь тусдаа орчинд боловсрол, эрүүл мэнд, спорт, соёл урлагийн зэрэг хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах нь хүүхэд эрсдэлт нөхцөлд орох, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, мөн эрх нь зөрчигдсэн, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах нь үр дүнтэй байх юм. Иймд хүүхдийг хөгжлийг дэмжих үйлчилгээний эрх зүйн үндсийг бий болгохоор 4 болон 6 дугаар зүйлд шинээр хэсэг, заалт нэмэхээр хуулийн төсөлд тусгасан болно.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p>10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг</p> <p>10.1.Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ:</p>	<p>“10.1.11.өөртөө болон бусдад давуу байдал бий болгох, ашиг хонжоо олох зорилгоор хүүхдийг эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;”</p>	<p>Заалт нэмэх</p>

#### Тайлбар:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг заасан ба энэ зүйлд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг “өөртөө болон бусдад давуу байдал бий болгох, ашиг хонжоо олох зорилгоор хүүхдийг эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;” үүргийг нэмэлтээр оруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүүхдийн нийгмийн амьдралд оролцуулах эрхийг хэрэгжүүлэхдээ ямар үүрэг хүлээх нь тодорхой болох бөгөөд цаашлаад энэ үүргээ зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээн эрх зүйн үндэслэл улам тодорхой болно.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p>20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах</p>	<p>“20.5.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тухайн орон нутгийн хүн амын тоо, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан 3 жил тутамд Засгийн газраас тогтооно.</p> <p>20.6.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д заасны дагуу Засгийн газраас баталсан, хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий</p>	<p>Хэсэг нэмэх</p>

	<p>үнэмлэх, тэмдэг, түүнчлэн зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p> <p>20.7.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгох, цуцлахдаа Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмыг нийтлэг байдлаар хэрэглэнэ.</p> <p>20.8.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлах ба хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална.”</p>	
--	--	--

### Тайлбар:

Дагаж мөрдөж буй Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн талаар зохицуулсан байдаг боловч хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах эрх зүйн орчин, түүнчлэн хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрхийг олгох, цуцлах холбоотой зохицуулалт байдаггүй. Иймд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоох, албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх тэмдэг хэрэглэх, мөн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас зэрэг эрх зүйн хэлбэр бүхий шийдвэрийн төрлийг хэрэглэдэг байх, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгох, цуцлахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгож, түүнчлэн хүүхдийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газраас батлахаар хуулийн төсөлд тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p>8.1.Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд хүүхэд нийгмийн амьдралд оролцохдоо дараах эрх эдэлнэ:</p> <p>8.1.2.хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;</p>	<p>“8.1.2.хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд оролцох, үзэл бодол, саналаа илэрхийлэх, өөрөө болон бусдаар уламжлан өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;”</p>	Өөрчлөн найруулах
<p>20.4.Улсын байцаагчийн эрх бүхий ажилтан нь хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулна.</p>	<p>“20.4.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, шалган шийдвэрлэх замаар хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангуулна.”</p>	Өөрчлөн найруулах
<p>20.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр таваас</p>	<p>20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “нийгмийн ухааны” гэснийг “нийгмийн ухаан, хууль зүйн” гэж,</p>	Өөрчлөн найруулах

доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна.	"таваас доошгүй" гэснийг "нэгээс доошгүй" гэж,
--	--

### Тайлбар:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхийн талаар заасан бөгөөд ингэхдээ 8.1.2 дахь заалтад хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох хэмээн явцуу (зөвхөн оролцох), нөгөө талаа хэт ерөнхий (оролцоходоо хэрхэн оролцох) байдлаар заасныг өөрчилж, хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд оролцох, үзэл бодол, саналаа илэрхийлэх, өөрөө болон бусдаа уламжлан өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх" хэмээн нарийвчлан заахаар 8.1.2 дахь заалтыг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.4-т хүүхдийн улсын байцаагч нь хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулна" гэж заасан нь оновчгүй байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь зөвхөн зөрчлийг шалган шийдвэрлэх буюу хүүхдийн эрх, хамгааллын холбогдох хууль журмуудын биелэлтэд хяналт тавих, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, илрүүлэх, таслан зогсоох, зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хүүхдийн эрхийг хангуулах ёстой ба ингэхдээ зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, шийтгэлийн хуудас зэрэг хууль зүйн үр дагавар бүхий шийдвэрүүдийг гаргаж ажиллах учиртай. Иймд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.4 дэх хэсгийн илүү боловсронгуй болгож өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгасан болно.

### Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
20 дугаар зүйл. Хамтарсан баг	"20.4.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага нь хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгч ажиллана."	Хэсэг нэмэх
5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 5.1.2."гэр бүлийн хүчирхийллийн хохирогч" /цаашид "хохирогч" гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод,	5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын "гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх", "/цаашид "хамтарсан баг" гэх/" гэснийг тус тус хассугай.	хасах

бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;	
12.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 12.2.4.хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгөх.	12.2.4-ийг хүчингүй болгох

### Тайлбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны баталсан ба 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хийсэн анхны нэмэлт, өөрчлөлтөөр Хамтарсан багтай холбоотой заалтад зарчмын нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд “Хүүхэд хамгааллын тухай хуульд орсон эдгээр өөрчлөлт нь тус хуулийн Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн нийцлийг бууруулсан гэдгийг цохон тэмдэглэх нь чухал гэж үзэж байна. Энэ өөрчлөлтөөр хүүхэд хамгааллын кейстэй ажиллах хамтарсан багийн үүрэг хариуцлагыг хэвээр хадгалсан ч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан багийг хариуцах чиг үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд шилжүүлсэн. Энэ шилжилт нь хүүхэд хамгаалалд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг хариуцах, төсөв хөрөнгийг хуваарилах, манлайлал, удирдлагын дэмжлэг үзүүлэх зэрэг зохицуулалтуудыг ухраахад хүргэсэн. Хүүхэд хамгааллын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд нь тус хуулийн хэрэгжилтийг сулруулж, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ авах үүргээ золиосолж, гэр бүлийн хүчирхийлэлд илүү анхаарах хэрэгтэй гэсэн төсөөлөл, хандлагыг бий болгосон” гэж дүгнэсэн.<sup>1</sup> Уг нэмэлт, өөрчлөлтөөр “Хамтарсан баг”-ийг Хүүхэд хамгааллын тухай хуулиас хасаж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд оруулахдаа “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх баг” явцууруулан томъёолж оруулсан байдаг.

Иймд дээр дурдсан алдааг засах үүднээс Хамтарсан багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудалд буцаан оруулах, үүнтэй холбоотойгоор хуулийн 12.2.4 дэх заалтыг хүчингүй болгох, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” гэсэн тодорхойлолтыг “Хамтарсан баг” гэж өөрчлөхөөр хуулийн төслийг боловсрууллаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь
20.1.Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.	“20.1.Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны хөгжлийн нийгмийн ажилтан, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.”

<sup>1</sup> Үнэлгээний тайлан, 44 дэх тал.

### Тайлбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл батлагдсанаар сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо шинээр бий болно. Иймд уг мэргэжилтнийг Хамтарсан багийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай. Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг заахдаа бичилт, нэршлийн хувьд ойлгомжтой байлгах үүднээс 20.1 дэх хэсгийг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
20.3.Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	"эрүүл мэндийн асуудал эрхэлсэн" гэснийг "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн" гэж өөрчилсүгэй.	өөрчлөх

### Тайлбар:

Засгийн газрын гишүүний эрх хэмжээний хүрээнд улсын төсвөөс зардал гаргахтай холбоотой дүрэм, журмыг батлах эрх хэмжээг хуулиар олгож байгаа тохиолдолд уг дүрэм, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний оролцоотойгоор батлах нь зүйтэй. Гэтэл Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг батлахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг оруулаагүй байгааг засахаар хуулийн төсөлд дээрх зохицуулалтыг тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь
21.1.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 21.1.2.асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; 21.1.4.хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;	21.1.2, 21.1.4-ийг тус тус хүчингүй болгох

### Тайлбар:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан дээрх заалт нь дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13.3-т "Хүүхэд асрах хувилбарт ... үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална" гэж, 10.5-д "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, ... батална" гэсэн зохицуулалттай зөрчилдсөн, давхардсан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 201 оны А/218 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, 2021 оны А/209 дүгээр тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөлд эдгээр журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан байгаа тул Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21.1.2, 21.1.4 дэх заалтыг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгасан болно.

**Гурав. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
5.2.Хүн худалдаалахтай тэмцэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	“5.2.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;”  “5.2.5.хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан баг байгуулах”.	заалт нэмэх

**Тайлбар:**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журмыг тусгаагүй орхигдуулсан тул энэ төрлийн хохирогч хүүхдийн эрх, ашгийг хамгаалах, нөхөн сэргээх нийгэмд бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх, хяналт тавих зохицуулалтыг журмаар зохицуулахаар тусгав.

Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улсын хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” гэрээний хүрээнд АНУ-ын Төрийн Департаментын санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт:Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төсөл хэрэгжиж байна. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1 дүгээр хуралдааны шийдвэрээр олон улсын сайн туршлага болох “хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан баг”-ийг байгуулж, туршилтын хүрээнд 2022 оноос ажиллаж эхэлсэн. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан баг байгуулах” нь үр дүнтэй байгаа бөгөөд цаашид холбогдох хуульд тусган эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзэж, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах зохицуулалтыг тусгав.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
9 дүгээр зүйл.Хамгаалах байр	“9.6.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”	хэсэг нэмэх

### Тайлбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгээс хүн худалдаалах гэмт хэрэг нь “аюул, хор хөнөөл ихтэй, урт хугацаанд байрлах, нууцлал болоод орчин нь бусад төрлийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнээс ялгаатай байх ёстой”. Гэвч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн /2016 оны шинэчлэл/ дагуу боловсруулж мөрдөж байгаа Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 нь энэ төрлийн хохирогчийг хамгаалах түр хамгаалах байранд мөрдөх боломжгүй тул эрх зүйн зохицуулалтад тусгах санал гарсан.

Иймд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
5.11.Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүн худалдаалахад өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн улсын хэмжээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулна.	“5.11.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүн худалдаалах үйлдэлд өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, сургалт, судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хэсэгт заасан чиг үүргийг гүйцэтгэхдээ мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж болно.”	хэсэг нэмэх

## Тайлбар:

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг холбогдох хуульд тодорхой тусгаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан боловсруулав.

## Дөрөв. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
	<p><b>19<sup>1</sup> дүгээр зүйл. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ</b></p> <p>19<sup>1</sup>.1.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг хамруулна.</p> <p>19<sup>1</sup>.2.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа хувь хүн, гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагад олгох хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.</p> <p>19<sup>1</sup>.3.Төрөл, садны болон асралт гэр бүлд шилжсэн хүүхдийн зардлын норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацааг энэ хуулийн 19.5-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.</p>	Шинэ зүйл нэмэх
8.2.Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:	8.2.10.хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ.	8.2 дахь хэсэгт шинэ заалт нэмэх

## Тайлбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээний “хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ”-г гэр бүлийн орчинд болон хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан үзүүлэхээр заасан. Хүүхдийг гэр бүлээс нь “хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ” үзүүлэхдээ “хүүхэд асрах хувилбар үйлчилгээгээ”-ний 1) хүүхдийг төрөл, садны гэр бүл асруулах, 2) хүүхдийг асралт гэр бүлд асруулах, 3) хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад асруулах гэсэн 3 хэлбэрийг ашиглахаар заасан. Үүнтэй холбогдуулан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхэлж байгаа этгээдэд олгох хувьсах болон үйлчилгээний зардал, түүнчлэн хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн норматив зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлдэг байхаар хуулийн төсөлд тусгасан болно.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг;	“3.1.3.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-д заасныг;”	Өөрчлөн найруулах

**Тайлбар:** Дагаж мөрдөж буй хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт “эрсдэлт нөхцөлд байгаа” хүүхдийг томъёоллыг Хүүхэд хамгааллын тухай хуулиар эш татахдаа буруу техник хэрэглэсэн байгааг зөвтгөж, өөрчлөн найруулахаар төсөлд тусгав.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
13.2.Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно: 13.2.2.Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа;	13.2.2.хүүхдийг асарч байгаа асралт гэр бүл;”	8.2 дахь хэсэгт шинэ заалт нэмэх

**Тайлбар:**

Дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуульд “асралт гэр бүл”-ийн талаарх зохицуулалт байхгүй. Харин Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн<sup>2</sup> зохицуулалт нь асралт гэр бүлийн тухай ойлголтыг илэрхийлдэг боловч асралт гэр бүл гэсэн нэр томъёог хэрэглээгүй байдаг. Төрөл, садны холбоогүй өөр хөндлөнгийн гэр бүл хүүхдийг гэр бүлдээ авч асрахыг асралт гэр бүл гэж ойлгох ба энэхүү гэр бүлд асаргааны тэтгэмж олгох талаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.2 дахь заалтад заажээ. Ингэхдээ найруулгын хувьд ойлгомжгүй байдлаар заасан байна. Харин Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “асралт гэр бүл” гэсэн нэр томъёог хэрэглэж, асралт гэр бүлд хүүхдийг асруулах харилцааг зохицуулахаар тусгасан байгаа тул Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.2 дахь заалтыг хуулийн шинэчлэлтэй холбогдуулан өөрчлөн найруулахаар шаардлагаар төсөлд тусгасан болно.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж тус тус өөрчилсүгэй.	8.2 дахь хэсэгт шинэ заалт нэмэх
--	----------------------------------

<sup>2</sup> Гэр бүлийн тухай хуулийн 74.1-д “Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж /цаашид “асран хүмүүжүүлэх” гэж/ болно” гэж заасан.

## Тайлбар:

Нийгмийн халамжийн тухай хуульд “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. Уг нэр томъёо нь Гэр бүлийн тухай хуульд бас хэрэглэгдсэн байдаг. Харин 1996 он батлагдаж, 2016 онд батлагдсан байгаа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэдгийг тодорхойлсон байдаг боловч 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг батлахдаа “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэдгийг хэрэглээгүй, үүний оронд “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, манай улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж ямар хүүхдийг ойлгохыг тайлбарласан зохицуулалт байхгүй байна. Нөгөө талаас, 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуульд “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн нэр томъёог Хүүхэд хамгааллын тухай хуулиас эш татаж оруулсан байдаг. Иймд цаашид нэр томъёог ойлгомжтой болгох, жигдрүүлэх “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэдэг ойлголтыг “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан болно.

## Тав. Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
55 дугаар зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нөхцөл	“55.9.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг жил бүр гаргаж хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”	шинэ хэсэг нэмэх

## Тайлбар:

Хүүхдийг зөвхөн түүний ашиг сонирхлыг үүднээс үрчлүүлэх тул эргээд үрчлэгдсэн хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих ёстой ба хэрэв үрчлэгдсэн хүүхдийн хөгжилд хохирол учруулах нөхцөл байдал, үндэслэл илэрвэл үрчлэлтийг хүчингүйд тооцуулах зэргээр хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээ авах ёстой. Энэ үүднээс Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлд дээрх хэсгийг нэмэлтээр оруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
66 дугаар зүйл. Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага	“66.4.Бүтэн өнчин хүүхэд, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага болон асралт гэр бүлд шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид	шинэ хэсэг нэмэх

	хариуцуулах тухай хүсэлтийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл сум, дүүргийн Засаг дарга тухайн хүн эсхүл эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргана.”	
--	--	--

**Тайлбар:**

Гэр бүлийн тухай хуулийн 66.3-т “Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг шүүх эрхлэн хамгаалагчид хариуцуулна” гэж заасан байдаг. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135.2-т “Эрх зүйн ач холбогдол бүхий дараах үйл явдлыг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтооно:” гээд 135.2.11-д “хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах” гэж заасан байдаг.

Гэвч дээрх хоёр хуульд тухайн хүсэлтийг аль шүүхэд, хэн гаргах талаарх процессыг зохицуулалт байдаггүй. Үүний улмаас бүтэн өнчин хүүхэд, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага болон асралт гэр бүлд шилжсэн хүүхдийн эд хөрөнгийг нь эрхлэн хамгаалагчид хариуцуулан, хөрөнгийг нь хамгаалах ажиллагаа бараг хийгдэхгүй байна. Энэ байдлыг засах зорилгоор Гэр бүлийн тухай хуулийн 66 дугаар зүйлд дээрх хэсгийг шинээр нэмэхээр тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
25.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садны хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.	“25.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.4, 25.5 заасан хүүхдийг өөрөө илрүүлсэн, эсхүл 25.6-д заасны дагуу хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл байдалд үнэлгээ хийлгүүлж, эцэг, эх болон төрөл, садны хүн байхгүй нь тогтоогдсон бол хүүхдийг асралт гэр бүл болон хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх, эсхүл үрчлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.”	Өөрчлөн найруулах

**Тайлбар:**

Гэр бүлийн тухай хуулийн 25.4-д “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно”, 25.5-д “Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн

чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална”, 25.6-д “Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй” гэж тус тус заасан.

Гэр бүлийн тухай хуулийн 25.8 дахь хэсгийн зохицуулалт нь үндсэндээ тухайн хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх талаарх зохицуулалт байна. Гэр бүлийн тухай хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхэд байгаа тохиолдолд юу түрүүнд Хамтарсан багаас хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх ёстой ба үүний үндсэн дээр хүүхэд хамгааллын дараах үйлчилгээг төлөвлөж хэрэгжүүлэх ёстой. Харин Гэр бүлийн тухай хуулийн 25.8 дахь хэсэг нь агуулгын одоогийн практиктэй нийцэхгүй, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан найруулга болоод нэр томъёоны хувьд тодорхой болгох, жигдлэх зорилгоор уг хэсгийг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгасан.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
28.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан бол хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ.	“28.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан бол хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах, боломжгүй тохиолдолд асралт гэр бүл, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад асруулахаар шилжүүлнэ.”	Өөрчлөн найруулах
31.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан бол уг хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох буюу, эсхүл түүнийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ.	“31.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан бол хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах, боломжгүй тохиолдолд асралт гэр бүл, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад асруулахаар шилжүүлнэ.”	Өөрчлөн найруулах

#### Тайлбар:

Эцэг, эх байх эрхийг хасах болох хязгаарласнаар тухайн хүүхэд гэр бүлээсээ тусгаарлагдах үр дагаврыг үүсгэдэг. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөлд зааснаар гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг 1) төрөл, садны гэр бүлд асруулах, 2) асралт гэр бүлд асруулах, 3) асрамж, халамжийн байгууллага буюу хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага асруулах гэсэн хүүхэд асрах хувилбар үйлчилгээний хэлбэрүүдийг хэрэглэхээр заасан.

Харин Гэр бүлийн тухай хуулийн 28.3, 31.3-т заасан зохицуулалтаар эцэг, эх байх эрхийг хязгаарлуулсан, хассан тохиолдолд хүүхдийг шууд хүүхэд асран

хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхээр заасан байгаа нь шинээр батлагдах Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн заалттай нийцэхгүй байгааг засах буюу хууль хоорондын уялдааг хангах зорилгоор Гэр бүлийн тухай хуулийн 28.3, 31.3 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
25.5.Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.	“эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан,” гэсний хасах	Хасах
55.3.Бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй бол хүүхдийг нь үрчлүүлэх тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын зөвшөөрлийг авна.	“55.3.Бүтэн өнчин хүүхдийг үрчлүүлэх тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын зөвшөөрлийг авна.”	Өөрчлөн найруулах
55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана.	“55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлт, бүрдэл хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хүүхдийг үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргах ба шаардлагатай гэж үзвэл уг хугацааг 15 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.”	Өөрчлөн найруулах
55.8.Хүүхэд үрчилсэн тухай шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ.	“55.8.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийг үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахдаа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.”	Өөрчлөн найруулах

### Тайлбар:

Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй тооцогдсон хүний хүүхдийг “бүтэн өнчин хүүхэд” гэсэн ойлголтод хамааруулахаар Нийгмийн халамжийн тухай хуульд заасан байдаг.<sup>1</sup> Иймд нэр томъёог жигдлэх үүднээс Гэр бүлийн тухай

<sup>1</sup> Нийгмийн халамжийн тухай хууль. 3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх

хуулийн 55.3 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар, мөн 25.5 дахь хэсгээс “эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан,” гэснийг хасахаар хуулийн төсөлд тусгасан.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11.4-т “Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 11.1, 11.3-т заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулна”, 11.5-д “Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг энэ хуулийн 11.4-т заасан дүгнэлтэд үндэслэн 20 хоногийн дотор гаргана.” гэж тус тус заасан нь Гэр бүлийн тухай хуулийн 55.7 дахь хэсэгтэй зөрчилддөг. Нөгөөтээгүүр, үрчлэлтийн харилцаатай холбоотой процедурын буюу журам тогтоосон зохицуулалтыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан нь тус хуулийн үндсэн зорилготой нийцэхгүй байна.<sup>1</sup> Өөрөөр хэлбэл, хүүхэд үрчлэлтийн асуудлын зохицуулах гол хууль нь Гэр бүлийн тухай хууль байх буюу бүртгэл хөтлөхөөс өмнөх харилцааг уг хуулиар зохицуулах нь оновчтой байна. Түүнчлэн сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахдаа хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулахаар зохицуулж байгаа нь хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс хангалтгүй байгаа тул аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсээр дүгнэлт гаргуулах шаардлагатай байна. Иймд Гэр бүлийн тухай хуулийн 55.7, 55.8 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгасан болно.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
74 дүгээр зүйл. Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа	Хүүхдийг асралт гэр бүлд асруулах	Өөрчлөх
74.1.Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж /цаашид “асран хүмүүжүүлэх” гэх/ болно.	“74.1.Сум, дүүргийн Засаг дарга гэр бүлээс нь тусгаарласан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асралт гэр бүлд асруулахаар шилжүүлж болно.”	Өөрчлөн найруулах
74.2.Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ нийгмийн халамжийн байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд тодорхой хугацаагаар гэрээ байгуулна.	“74.2.Хүүхдийг асралт гэр бүлд асруулахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Хүүхэд хамгааллын тухай хуулиар зохицуулна.”	Өөрчлөн найруулах
74.3.Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон нийгмийн халамжийн байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад хөнгөлөлт, гэрээ	74.3-74.8 дахь хэсгийг хүчингүй болгох	Хүчингүй болгох

эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;  
<sup>1</sup> Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь иргэний улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ.

<p>дуусгавар болох үндэслэл, үр дагаврыг заана.</p> <p>74.4.Хүүхдийг асран хүмүүжүүлэхэд тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл буй болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол нийгмийн халамжийн байгууллагын шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан /өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ буй болсон бол асран хүмүүжүүлэгчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.</p> <p>74.5.Асран хүмүүжүүлэхээр шилжүүлэхдээ долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна.</p> <p>74.6.Асран хүмүүжүүлэхээр шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах, хууль тогтоомжийн дагуу орон сууцаар хангагдах эрх эдэлнэ.</p> <p>74.7.Энэ хуулийн 74.3-т зааснаар асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулалд шаардагдах зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.</p> <p>74.8.Энэ хуулийн 66.2-т заасны дагуу нийгмийн халамжийн байгууллага асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар асран хүмүүжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина.</p>		
<p><b>75 дугаар зүйл. Асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болохгүй хүн</b></p> <p>75.1.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, асран хүмүүжүүлж байсан буюу үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлж байсан болон хорих ял эдэлж байгаа</p>	<p>Тус зүйлийг хүчингүй болгох</p>	<p>Хүчингүй болгох</p>

хүнтэй асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хориглоно.		
---	--	--

### Тайлбар:

Гэр бүлийн тухай хуульд иргэн бусдын хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагааг зохицуулахдаа “асран хүмүүжүүлэгч” гэх нэр томъёог хэрэглэсэн байдаг. “Асран хүмүүжүүлэгч” нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон хүнээс өөр субъект болох нь тус хуулийн 74 дүгээр зүйлийг “Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа” гэж гарчигласан, мөн зүйлийн 74.1-д “Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж /цаашид “асран хүмүүжүүлэх” гэх/ болно”, 74.7-д “Энэ хуулийн 74.3-т зааснаар асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулалд шаардагдах зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ”, 74.8-д “Энэ хуулийн 66.2-т заасны дагуу нийгмийн халамжийн байгууллага асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар асран хүмүүжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина” гэж зааснаас харагддаг.

Өөрөөр хэлбэл, “foster family” буюу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тусгаад байгаа “асралт гэр бүл” гэх ойлголтыг 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг батлахдаа “хүүхдийг гэр бүлдээ асран хүмүүжүүлэх” буюу “асран хүмүүжүүлэгч” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. “Асралт гэр бүл” гэдэг нь хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн хүүхэдтэй төрөл, садны биш гэр бүлийг ойлгодог.

Энэ утга нь Гэр бүлийн тухай хуулийн 25.9-д “Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно”, 25.10-д “Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ” гэх зэргээр зааснаас бас харагддаг.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “хүүхдийг асралт гэр бүлд асруулах” үйл ажиллагааг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нэг хэлбэр болгон заахдаа Гэр бүлийн тухай хуулийн 74, 75 дугаар зүйлийн илүү боловсронгуй болгон оруулж байгаа ба “асран хүмүүжүүлэгч” гэх ойлголтыг “асралт гэр бүл” гэх ойлголтоор хуулийн төсөлд тусгасан болно.

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь
25.7.Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.	Хүчингүй болгох
25.9.Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно.	Хүчингүй болгох

25.10.Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хүчингүй болгох

### Тайлбар:

Гэр бүлийн тухай хуулийн 25.7-д “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.” гэж заасан. Харин Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг 2013.07.05-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон тул уг 25.7 дахь хэсгийг хүчингүй болгохоор хуулийг төсөлд тусгалаа.

Гэр бүлийн тухай хуулийн 25.9 дахь хэсгийн зохицуулалт нь тус хуулийн 74, 75 дугаар зүйлийг зохицуулалттай уялддаг. 74, 75 дугаар зүйлийн зохицуулалт нь асралт гэр бүлийн талаарх зохицуулалт болохыг дээр тайлбарласан ба хүүхдийг асралт гэр бүлд асруулахтай холбоотой харилцааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дэлгэрэнгүй байдлаар тусгаж байгаа тул 25.9 дахь хэсгийг хүчингүй болгохоор тусгалаа. Дарааллын хувьд хүүхдийг эхлээд төрөл, садны гэр бүлд асруулах, боломжгүй тохиолдолд асралт гэр бүлд эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлж асруулах ёстой. Гэтэл Гэр бүлийн тухай хуулийн 25.9, 25.10 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд хүүхдийг эхлээд асралт гэр бүлд шилжүүлж асруулах боломжгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр заасан нь учир дутагдалтай байна. Энэ нь 25.9 дэх хэсгийг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгах бас нэгэн үндэслэл болсон. Гэр бүлийн тухай хуулийн 25.8 дахь хэсгийг өөрчлөн найруулахдаа 25.10 дахь хэсгийн зохицуулалтын агуулгыг илүү боловсронгуй болгож тусгасан тул уг хэсгийг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

### Бусад:

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016.02.05-ны өдөр батлахдаа Гэр бүлийн тухай хуулийн нэр томьёог тайлбарласан 3 дугаар зүйлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ойлголтыг тодорхойлсон заалтыг эш татаж заасан байдаг<sup>1</sup> боловч Гэр бүлийн тухай хуульд “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн нэр томьёо үүнээс өөр газар хэрэглэгдээгүй, харин “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн нэр томьёо хэрэглэгдсэн байдаг.

Иймд Нэр томьёог жигдлэх зорилгоор Гэр бүлийн тухай хуульд туссан байгаа “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ойлголтыг “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн

<sup>1</sup> Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйл.

3.1.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг. Жич: Зүйл нь “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасныг гэж бичих ёстой байсан боловч бичилтийн буруу техникийг ашигласан байгааг засахаар хуулийн төсөлд тусгасан болно.

ойлголтоор өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан болно. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “асралт гэр бүл”-ийн зохицуулалт тусгагдсан байгаа тул Гэр бүлийн тухай хуулийн “асран хүмүүжүүлэгч” гэсэн ойлголтыг “асралт гэр бүл” гэх ойлголтоор өөрчлөхөөр тусгасан. Түүнчлэн Гэр бүлийн тухай хууль нь 1999 он батлагдсан буюу хүүхэд, гэр бүлийн асуудлыг дагнан хариуцсан төрийн байгууллага байхгүй байхад батлагдсан хууль юм. Иймд одоо хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага хариуцах ёстой, хариуцаж байгаа чиг үүргийг Гэр бүлийн тухай хуулийн нийгмийн халамжийн байгууллагад хариуцуулахаар заасан байгааг өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан болно.

### Зургаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p><b>3.5 дугаар зүйл.Хууль ёсны төлөөлөгч</b>            2.Энэ зүйлийн 1.1 дэх заалтад заасны<sup>1</sup> дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.</p>	Энэ зүйлийн 1.1 дэх заалтад заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон хүн хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй болсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр өөрчлөн тогтооно.”	2 дахь өгүүлбэр нэмэх
<p><b>4.3 дугаар зүйл.Үзлэг хийх</b>            3.Хүний биед хийх үзлэгийг энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.8, 6.11, 6.13, 6.24, 6.25, 6.62 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтан хийнэ.</p>	“Арван найман насанд хүрээгүй хүний биед үзлэг хийх ажиллагаанд хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг байлцуулна.” гэсэн агуулгатай 2 дахь өгүүлбэр	2 дахь өгүүлбэр нэмэх

#### Тайлбар:

1. Хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад хүүхдийнхээ хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэйгээ ашиг сонирхлын зөрчилтэй болсон нь тогтоогдсон буюу хувийн ашиг сонирхлын үүднээс, тухайлбал, эсрэг талтайгаа тохиролцох, гомдол, саналаасаа татгалзах зэргээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахгүй, ашиг сонирхлын зөрчилтэй болох тохиолдол гардаг. Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан урьд томилсон хууль ёсны төлөөлөгчийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнаар өөрчилж томилох зохицуулалт байхгүй байгаа нь

<sup>1</sup> 1.Эрх бүхий албан тушаалтан дараах хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно:

1.1.арван найман насанд хүрээгүй холбогдогч, хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;

учир дутагдалтай байгаа тул уг асуудлыг зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан болно.

2. Хүүхдээс мэдүүлэг авах ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчийг оролцуулах, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтныг байлцуулахаар тусгасан боловч хүүхдийн биед үзлэг хийх ажиллагаанд хэнийг оролцуулах, байлцуулах талаар тусгаагүй нь учир дутагдалтай байна. Иймд хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс хүүхдийн биед үзлэг хийх ажиллагаанд хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг байлцуулдаг байхаар хуулийн төсөлд тусгалаа.

### Долоо. Эрүүл мэндийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
16 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг 16.18.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь оюутан, сурагчдад харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	“Сурагчдад” гэснийг “хүүхдэд” гэж өөрчлөх	Өөрчлөх

#### Тайлбар:

Боловсролын тухай хуульд “сурагч”, “суралцагч” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, боловсролын харилцааны хүрээнд хүүхдийг сурагч, суралцагч нэрлэж статусыг нь тодорхойлж байгаа тул сурагчдад харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ гэж заах нь оновчгүй байна. Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн 16.18 дахь хэсгийн “сурагчдад” гэсэн үгийг “хүүхдэд” гэж өөрчлөхөөр хуулийн төслийг боловсруулсан болно.

### Найм .Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
6.1.Доор дурдсан хүн /цаашид “үйлчлүүлэгч” гэх/-д энэ хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлнэ: 6.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.	“4.1.1-д” гэснийг “1.4 дүгээр зүйлийн 1.3-д” гэж өөрчлөх	Өөрчлөх

**Тайлбар:**

Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбоотойгоор Хууль зүйн туслалцааны тухай хуульд Хүүхэд хамгааллын тухай хуулиас “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэдгийг тодорхойлсон заалтыг эш татсан хэсэгт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан болно.

**Ес. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
15 дугаар зүйл.Гамшгийн үеийн үйл ажиллагаа	“15.4.Гамшгийн үед хүүхэд хамгааллын үйлчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандартыг баримтлан үзүүлнэ.”	Хэсэг нэмэх

**Тайлбар:**

“Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ойлголтод “гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд” хамаарч байгаа. Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлд “гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал”-ын асуудлыг тусгасан. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2023.03.24-ний 1/1473 тоот албан бичгээр хуулийн төсөлд тусгагдсан энэ зохицуулалт нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан зохицуулалттай нийцэхгүй байгааг засах санал өгснийг судлан үзэж, гамшгийн үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хэрхэн хүргэх талаарх эрх зүйн зохицуулалтыг тухайн хуульд зааж оруулах нь зүйтэй гэж үзэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд дээрх дээрх хэсгийг нэмэлтээр оруулахаар хуулийн төслийг боловсруулсан болно.

**Арав.Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<p><b>18 дугаар зүйл.Онц байдлын үед үл хөндөгдөх иргэний эрх, эрх чөлөө</b>  Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоох хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг үл хөндөнө.</p>	<p>Онц байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандартыг баримтлан үзүүлнэ.</p>	<p>2 дахь өгүүлбэр нэмэх</p>

**Тайлбар:**

“Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ойлголтод “гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд” хамаарч байгаа. Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлд “гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал”-ын асуудлыг тусгасан. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2023.03.24-ний 1/1473 тоот албан бичгээр хуулийн төсөлд тусгагдсан энэ зохицуулалт нь Онцгой байдлын тухай хуульд заасан зохицуулалттай нийцэхгүй байгааг засах санал өгснийг судлан үзэж, дагуу онц байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хэрхэн хүргэх талаарх эрх зүйн зохицуулалтыг тухайн хуульд нь зааж оруулах нь зүйтэй гэж үзэж Онц байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд дээрх 2 дахь өгүүлбэрийг нэмэлтээр оруулахаар хуулийн төслийг боловсруулсан болно.

**Арван нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь	
<b>1 дүгээр зүйл.</b> Төрийн хэмнэлтийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй. <b>1/ 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:</b>	“3.4.Хүүхэд хамгааллын санхүүжилтийн эх үүсвэрийг батлахад энэ хууль хамаарахгүй.”	Заалт нэмсэн
<b>6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл</b> 6.5.Дараах байгууллага, үйлчилгээнд энэ хуулийн 6.3 дахь хэсэг <sup>1</sup> хамаарахгүй:	“6.5.19.хүүхэд хамгааллын үйлчилгээ;”	Заалт нэмэх

**Тайлбар:**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль 6.3-д зааснаар тус хуулийн үйлчлэлд хамаарч буй этгээд нь “орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэж заасан. Харин мөн хуулийн 6.5-д үүнд хамаарахгүй байгууллага, үйлчилгээг жагсаалтаар зааж оруулахдаа “хүүхэд хамгааллын үйлчилгээ”-нд тээврийн хэрэгсэл ашиглаж болохыг заагаагүй нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд бэрхшээл учруулж байгаа тул Төрийн хэмнэлтийн тухай хуульд дээрх байдлаар нэмэлт, оруулах хуулийн төслийг боловсруулсан болно. Тус хуулийн 6.5 дахь хэсэгт “6.5.19.хүүхэд хамгааллын үйлчилгээ;” гэсэн заалт нэмж байгаатай холбогдуулан одоогийн мөрдөгдөж буй 6.5.19 дахь заалтын дугаарлалтыг “6.5.20” гэж өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан болно.

<sup>1</sup> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэж заасан.

**Арван хоёр. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Хуулийн төсөлд тусгасан нь
<p><b>11 дүгээр зүйл. Үрчилсний бүртгэл</b>                      11.4. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 11.1, 11.3-т заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулна.                      11.5. Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг энэ хуулийн 11.4-т заасан дүгнэлтэд үндэслэн 20 хоногийн дотор гаргана.</p>	<p>11.4, 11.5 дахь хэсгийг хүчингүй болгох</p>

**Тайлбар:**

Гэр бүлийн тухай хуулийн 55.7-д “Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана” гэж заасан байдаг. Гэтэл Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд сум, дүүргийн засаг дарга хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулснаас хойш 20 хоногийн дотор хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахаар заасан нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна.

Нөгөөтээгүүр, үрчлэлтийн харилцаатай холбоотой процедурын буюу журам тогтоосон зохицуулалтыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан нь тус хуулийн үндсэн зорилготой нийцэхгүй байна.<sup>1</sup> Өөрөөр хэлбэл, хүүхэд үрчлэлтийн асуудлын зохицуулах гол хууль нь Гэр бүлийн тухай хууль байх буюу бүртгэл хөтлөхөөс өмнөх харилцааг уг хуулиар зохицуулах нь оновчтой гэж гэж үзсэн. Түүнчлэн сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахдаа хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулахаар зохицуулж байгаа нь хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс хангалтгүй байгаа тул аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтсээр дүгнэлт гаргуулах шаардлагатай байна.

Иймд дээрх байдлаар үүсэж буй хуулийн давхардал, хийдлийг арилгах болон зохицуулалтын үр нөлөөг сайжруулах зорилгоор дагалдан боловсруулсан Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.7, 55.8 дахь хэсгийг өөрчлөн найруулж<sup>2</sup> байгаатай холбоотойгоор Иргэний

<sup>1</sup> Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь иргэний улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ.

<sup>2</sup> 55 дугаар зүйлийн 55.7, 55.8 дахь хэсэг:

“55.7. Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлт, бүрдэл хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хүүхдийг үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргах ба шаардлагатай гэж үзвэл уг хугацааг 15 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.”

“55.8. Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийг үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахдаа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.”

улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсгийг хасахаар хуулийн төслийг боловсруулсан болно.

**Тайлбар:**

Гэр бүлийн тухай хуулийн 55.7-д “Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана” гэж заасан байдаг. Гэтэл Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд сум, дүүргийн засаг дарга хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулснаас хойш 20 хоногийн дотор хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг гаргахаар заасан нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна.

**Арван гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай**

Дагаж мөрдөж буй хуулийн зохицуулалт	Заалт нэмэх	Хуулийн төсөлд тусгасан нь
1 дүгээр зүйл. Улсын Их Хурлаас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дараах агуулга бүхий заалт нэмсүгэй.	“7.1.10.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4-т заасан хүүхэд хамгааллын бодлого байхгүй хуулийн этгээд.”  2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	нэмсэн

**Тайлбар:**

Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбоотойгоор хуулийн этгээд хүүхэд хамгааллын бодлого батлан мөрдөх зохицуулалт оруулсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд заалт нэмсэн болно.

## **ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ** */Шинэчилсэн найруулга/*

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго**

1.Энэ хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино.

#### **1.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж**

1.Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тогтоосон хуулийн хэм хэмжээ зөрчилдвөл хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэнэ.

#### **1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түр болон байнга оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд энэ хууль үйлчилнэ.

3.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18-аас 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

4.Үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах талаар Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулаагүй бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

#### **1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.1.“хүүхдийн сайн сайхан байдал” гэж хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгэмшил, танин мэдэхүй, боловсрол, эдийн засгийн хэрэгцээ шаардлага хангагдсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг;

1.2.“хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

1.3.“хүүхдийн эсрэг хүчирхийлэл” /цаашид “хүчирхийлэл” гэх/ гэж хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц үл хайхрах, сэтгэл санаа, бие махбод, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.4.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж дараах хүүхдийг ойлгоно:

1.4.а.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд;

1.4.б.хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд;

1.4.в.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд;

1.4.г.гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд.

1.5.“хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж дараах хүүхдийг ойлгоно:

1.5.а.гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд;

1.5.б.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;

1.5.в.зөрчилд холбогдогч хүүхэд;

1.5.г.зөрчил үйлдэж шийтгэгдсэн, эрүүгийн хариуцлага хүлээсэн, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд;

1.5.д.иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд.

1.6.“гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийг;

1.7.“үе тэнгийн дээрэлхэлт” гэж нэг буюу хэд хэдэн хүүхэд өөр нэг буюу хэд хэдэн хүүхдийг бие махбод, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ санаатайгаар, удаа дараа биеэр, амаар болон цахим орчинд үйлдэхийг;

1.8.“хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг;

1.9.“хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар

шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй, орон нутгийн олон талт орон тооны бус нэгжийг;

1.10.“хамтарсан баг” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасныг;

1.11.“асралт гэр бүл” гэж энэ хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тодорхой хугацаанд асран халамжилж байгаа хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн хүүхдийн төрөл, садны биш гэр бүлийг;

1.12.“кейс менежмент” гэж хүүхэд, гэр бүлд чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхой үе шатаар хүргэх, зохицуулах, хяналт тавих мэргэжлийн үйл ажиллагааг;

1.13.“хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага” гэж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажлын мэргэжилтнийг онол, арга зүйн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагааг.

2.Энэ хуульд заасан нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.

## **1.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын зарчим**

1.Хүүхэд хамгаалалд дараах зарчмыг баримтална:

1.1.хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

1.2.хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах;

1.3.хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;

1.4.хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд нэн тэргүүнд төрөл, садны гэр бүлийн асрамжид байлгахыг эрмэлзэх, хүүхдийг аль болох ах, эгч, дүүтэй нь хамт байлгах;

1.5.хүүхдээ хамгаалах чадвартай, хүсэл эрмэлзэлтэй эцэг, эхгүй бол төр хүүхдийг хамгаалах;

1.6.төр хүүхдийг хамгаалахдаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах;

1.7.хүүхдийн нөхцөл байдал, ялгаатай онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх.

2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэдтэй шууд харьцаж ажилладаг болон бусад хүнд хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдэд зааж сургахдаа бие махбодын шийтгэл хэрэглэх, гутаан доромжлохыг хориглоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **2.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын тогтолцоо**

1. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.

2. Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

3. Төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй.

4. Ажил олгогч, хуулийн этгээд нь дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Тайлбар: - Энэ хуульд заасан “хүүхэд хамгааллын бодлого” гэж тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилго, зорилт, ажилтны мөрдөх ёс зүйн хэмжээг тодорхойлсон тухайн байгууллага, хуулийн этгээдээс баталсан баримт бичгийг ойлгоно.

### **2.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт**

1. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт нь Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэнэ.

2. Монгол Улсад хүүхдийг хамгаалах үйл ажиллагаанд хүн, хувийн эрх зүйн хуулийн этгээдийг энэ хуульд заасны дагуу оролцуулж болно.

### **2.3 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг**

1. Засгийн газар нь хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хангах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгах, хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй.

**2.4 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

1.2.хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран ажиллах;

1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх дундын мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг батлах;

1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмыг батлах;

1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр, журмыг батлах;

1.6.хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчид зориулсан сургалтын хөтөлбөр, журмыг батлах;

1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

**2.5 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө жил бүр хариуцан тайлагнах;

1.2.хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, хүүхэд харагч, өдөр өнжүүлэх төв, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

1.5.хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан, хүүхэд хамгааллын цахим хувийн хэргийн санг хөгжүүлэх, ашиглах;

1.6.хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөгжүүлэх;

1.7.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үнэлэх, дүгнэх;

1.8.хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын салбар дундын хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах, уялдааг хангах;

1.9.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллага, их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;

1.10.хуулийн этгээд, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагч, ажилтнуудыг хүүхэд хамгааллын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх талаар тухайн байгууллагатай хамтран ажиллах;

1.11.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах талаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.12.хуулийн этгээд нь хүүхэд хамгааллын бодлого баталж, хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

1.13.хүүхэд хамгааллын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах;

1.14.хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээд хүн, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

1.15. барилга байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч эсхүл хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөллийг оруулах асуудлыг эрх бүхийн этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

1.16.хуульд заасан бусад чиг үүрэг.

## **2.6 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүрэг**

1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын талаарх судалгаа, тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг эрэмбэлэн тодорхойлох;

1.2.хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тандалт, судалгаа явуулах, бүртгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо болон хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх дундын мэдээллийн санд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.5.хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг байгуулах;

1.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нэгдсэн бүртгэл, судалгаа хөтөлж, мэдээллийн санд оруулах;

1.7.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэх талаар хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

1.8.магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллах;

1.9.гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хамгаалах талаар шаардлагатай зөвлөгөө, сургалт, тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

1.10.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.11.төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, бусад хуулийн этгээдийн ажилтан, алба хаагчдыг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

1.12.хуульд заасан бусад чиг үүрэг.

2.Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэгээр хангаж ажиллана.

3.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

4.Дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

## **2.7 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан**

1.Нийгмийн ажилтны мэргэжлээр дээд боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан хүнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна.

2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан доор дурдсан үүрэг хүлээнэ:

2.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгах;

2.2.шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

2.3.эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, эдгээрт үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, хаах, эргэн хянах;

2.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд кейс менежмент хийх;

2.5.хүүхэд хамгааллын кейс бүрд хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явцыг холбогдох журам, зааврын дагуу бүртгэх, баримтжуулах, архивлах, мэдээллийн санд оруулах;

2.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх тайлан, мэдээллийг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тухай бүр хүргүүлэх;

2.7.хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

2.8.хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон байж болзошгүй нөхцөл байдлын талаар харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэх;

2.9.нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх.

3.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан доор дурдсан эрх эдэлнэ:

3.1.хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн талаар, түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүүхдийг төлөөлөн холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

3.2.хүүхэд хамгааллын асуудлаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад хүн, хуулийн этгээд, олон нийтэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

3.3.мэргэжлийн ёс зүй, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

3.4.хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотойгоор мэдээ, мэдээлэл, баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

3.5.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах нөхцөл үүсэхээр бол хууль сахиулагчийн туслалцааг авах.

4.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ёс зүйн дүрэмтэй байх ба уг дүрмийг мэргэжлийн холбоодтой зөвшилцөн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална.

7.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална.

8.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

## **2.8 дугаар зүйл.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн чиг үүрэг**

1.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хүүхэд хамгааллын асуудлаар Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

## **2.9 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг**

1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.1.аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хангах үйл ажиллагаа, арга хэмжээг тусгаж, биелэлтэд нь хяналт тавих;

1.2.хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгайлан тусгаж батлах;

1.3. жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх;

1.4. хуульд заасан бусад чиг үүрэг.

## **2.10 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын чиг үүрэг**

1. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1. хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

1.2. тухайн шатны жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг тусгах;

1.3. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь тусламж, дэмжлэг үзүүлэх;

1.4. хуульд заасан бусад чиг үүрэг.

2. Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1. хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

2.2. хүүхэд хамгааллын үйлчилгээнд хууль тогтоомж, стандартыг сахин мөрдөж байгаа эсэхэд харьяалал, өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;

2.3. тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4. хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах;

2.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаар хамтарсан багийг ахлах;

2.6. хуульд заасан бусад чиг үүрэг.

3. Баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх ажлыг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран хэрэгжүүлэх;

3.2. хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдалд тандалт судалгаа хийж, шаардлагатай асуудлыг дээд шатны Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаар хамтарсан багийг ахлах;

3.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

## **I дэд бүлэг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг**

### **2.11 дүгээр зүйл.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо**

1.Аймаг, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид “хууль зүйн хороо” гэх/-г тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.

2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын; нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын албаны; боловсролын; эрүүл мэндийн; хөдөлмөр, халамжийн үйлчилгээний; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны; Засаг даргын ажлын албаны хууль, эрх зүйн асуудал асуудал хариуцсан нэгжийн; цагдаагийн; шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын; прокурорын газрын; шүүхийн тамгын газрын удирдах албан тушаалтнуудаас бүрдэнэ.

3.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, олон улсын байгууллагын төлөөлөл, хүн болон хуульч, өмгөөлөгчдийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухайн орон нутаг дахь салбар, нэгжийн төлөөллийг оруулж болно.

4.Хууль зүйн хороог шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж, сум буюу сум дундын прокурорын газар болон шүүх ажиллаж байгаа сумдад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр сумын Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулж болно.

5.Энэ зүйлийн 2-т заасан нэгж аймаг, дүүрэг, суманд байхгүй бол тухайн асуудлыг хариуцсан албан хаагчийг хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд оруулна.

6.Хууль зүйн хорооны даргын үүргийг Засаг дарга эсхүл түүний даалгаснаар Засаг даргын орлогч гүйцэтгэнэ.

7.Хууль зүйн хорооны гишүүн нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хууль зүйн хороо, түүний Ажлын албыг мэдээллээр хангах, хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг харьяа байгууллагын хэмжээнд хариуцан гүйцэтгэх үүрэгтэй.

8.Хууль зүйн хорооны гишүүн хууль зүйн хороонд хандсан, үйлчилгээ авсан хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн талаарх хүний хувийн болон эмзэг мэдээллийг задруулаагүй байх үүрэгтэй.

9.Хууль зүйн хороо нь Ажлын албатай байх ба уг Ажлын албаны чиг үүргийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага гүйцэтгэнэ.

10.Хууль зүйн хорооны нарийн бичгийн даргын үүргийг Ажлын албаны дарга гүйцэтгэнэ.

## 2.12 дугаар зүйл.Хууль зүйн хорооны чиг үүрэг

1.Хууль зүйн хороо нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд дараах үйлчилгээг үзүүлэхээр шийдвэр гаргаж, биелэлтийг хангаж ажиллана:

1.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

1.2.шаардлагатай тохиолдолд хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө бага насны хүүхдийн мэдүүлгийг дуу, дуу-дүрсний бичлэгээр урьдчилан баталгаажуулж авах ажлыг зохион байгуулах;

1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд эцэг, эх, гэр бүлийн гишүүд болон бусад этгээдийн дарамт, шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүүхэд өөрөө бие даан шийдвэр гаргах, саналаа хэлэх нөхцөлийг хангах;

1.4.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

1.5.хүүхдийг хорт зуршлаас ангижрах эмчилгээ, зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах;

1.6.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, зөрчилд холбогдогчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, эрх бүхий албан тушаалтантай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

1.7.гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхдээс болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авснаас бусад тохиолдолд өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, холбогдогчоос тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг хүүхдийн байгаа газарт нь зохион байгуулах арга хэмжээг авах;

1.8.хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд олгох сургалт, хүмүүжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

1.9.хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг сурч боловсрох эрхээ эдлэхэд шаардлагатай орчин, нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулах;

1.10.хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг хугацаанаас өмнө нь суллуулах асуудлаар хорих байгууллага, прокурорт санал гаргах, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүүхдэд хяналтын хугацаанд үүрэг хүлээлгэсэн тохиолдолд уг үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.11. тогтоолын биелэлтийг хойшлуулсан, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.12. хорих ял, баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эцэг, эх, харгалзан дэмжигчгүй хүүхдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, баривчлах байр, цагдан хорих төвөөс суллагдсан үед нь хүлээн авч, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах зохих байгууллагад шилжүүлэх;

1.13. өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, зөрчилд холбогдогч, эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэл хүлээсэн хүүхдийг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрт хамруулах;

1.14. сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд, түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах;

1.15. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд хууль зүйн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах;

2. Хууль зүйн хороо нь үйл ажиллагааныхаа жилийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийг боловсруулж тухайн шатны Хүүхдийн төлөө зөвлөлөөр батлуулна.

3. Хууль зүйн хорооны шийдвэр, үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх үүргийг Ажлын алба хэрэгжүүлж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

## **2.13 дугаар зүйл. Хууль зүйн хорооны хуралдаан, түүнээс гарах шийдвэр**

1. Хууль зүйн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас гарах шийдвэр нь тогтоол, зөвлөмж хэлбэртэй байна.

2. Хууль зүйн хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3. Хууль зүйн хорооны хуралдааныг энэ хуулийн 2.14 дүгээр зүйлд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор, шаардлагатай тохиолдолд дарга эсхүл хоёр буюу түүнээс дээш гишүүний санаачилгаар хийнэ.

4. Ажлын алба хууль зүйн хорооны хуралдаан болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, холбогдох баримт бичгийг гишүүдэд тараасан байна.

5. Хууль зүйн хороо хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

6.Хууль зүйн хороо хэвлэмэл хуудастай байна. Хууль зүйн хорооны шийдвэрт тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын тэмдгийг хэрэглэнэ.

7.Хууль зүйн хорооны шийдвэрийг хэрэгжүүлээгүй эсхүл хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн албан хаагчид сахилгын хариуцлага тооцуулах саналыг хууль зүйн хороо эрх бүхий этгээдэд хүргүүлж болно.

#### **2.14 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар хууль зүйн хороонд мэдэгдэх үүрэг**

1.Доор дурдсан этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг харьяа хууль зүйн хорооны ажлын албанд хүргүүлнэ:

1.1.эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага нь өсвөр насны сэжигтэн, яллагдагч, зөрчилд холбогдогч, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхдийн мэдээллийг тухай бүр;

1.2.шүүх нь шүүхэд шилжүүлсэн өсвөр насны яллагдагч, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, ял шийтгэгдсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон хүний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийн мэдээллийг тухай бүр;

1.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн мэдээллийг ялын хугацаа дуусахаас хамгийн багадаа 30 хоногийн өмнө, бусад үндэслэлээр суллагдсан тохиолдолд ийнхүү суллагдсанаас хойш 3 хоногийн дотор.

2.Хууль зүйн хорооны Ажлын алба энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг хүлээн авсан эсхүл өөрөө олж авсан тохиолдолд Хууль зүйн хороогоор зохих шийдвэрийг гаргуулж, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

3.Хууль зүйн хорооны Ажлын алба хэрэг хянан шийдвэрлэх оролцогч хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг кейс менежментийн үе шатны хүрээнд үзүүлнэ.

4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд, түүний гэр бүлд хийсэн нөхцөл байдлын үнэлгээний тайланг эрх бүхий этгээдэд хүргүүлэх ба эрх бүхий этгээд нөхцөл байдлын үнэлгээний тайланг хэргийн материалд хавсаргаж, нотлох баримтаар үнэлэх эрхтэй.

5.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхэд харьяа хууль зүйн хороо, түүний Ажлын албатай тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусах хүртэл хугацаанд хамтран ажиллана.

## 2.15 дугаар зүйл.Хамтарсан баг

1.Хамтарсан баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

2.Хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд туслах үүрэгтэй.

3.Хамтарсан багийн гишүүн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх явцад хамтарсан багтай хамтран ажиллаж байгаа хүн, хуулийн этгээд нь хүүхдийн мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд тэднээс нууц хамгаалах баталгааг бичгээр авна.

## 2.16 дугаар зүйл.Хамтарсан багийн чиг үүрэг

1.Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;

1.2.хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд аюултай нөхцөлд байдалд орсон бол шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх;

1.3.хүүхэд эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах;

1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

1.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулах;

1.6.тухайн жилд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийн саналыг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлэх.

2.Хамтарсан баг нь хүүхэд, гэр бүлд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг мэдээллийн санд бүртгэж, харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

## 2.17 дугаар зүйл.Хамтарсан багийн зохион байгуулалт

1.Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд хамтарсан багийн гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.Хамтарсан багийн нарийн бичгийн даргын үүргийг сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

3.Хамтарсан багийн хуралдаанаас гарах шийдвэр нь дүгнэлт, тэмдэглэл хэлбэртэй байна.

### **2.18 дугаар зүйл.Хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын оролцоо**

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг тухайн чиглэлээр мэргэшсэн хүн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээдийн мэдээллийн санг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэж, хөтөлнө.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хүн, хуулийн этгээд мэргэжлийн ёс зүйн дүрэм, нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

4.Хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хүн, хуулийн этгээд гэрээний үүргээ удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн, хүчирхийлэл үйлдсэнийг шүүх, хүүхдийн эрхийн улсын байцаагч, бусад эрх бүхий албан тушаалтан тогтоосон тохиолдолд тухайн этгээдийг хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах үндэслэл болно.

5.Энэ зүйлийн 4-т заасан нөхцөл үүссэн бол хүүхдийн эрхийн улсын байцаагч тухайн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах саналаа, холбогдох нотлох баримтын хамт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 4-т заасан нөхцөл үүссэнийг тогтоосон тухай энэ зүйлийн 5-д заасан эрх бүхий улсын байцаагчийн саналыг үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтөлж, нийтэд мэдээлнэ.

7.Хүн, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа нь энэ тухай хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй байна.

8.Хүн, хуулийн этгээд хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагааны тодорхой хэсгийг санхүүжүүлэх, хандив өгөх, бусад хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.

9.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

10.Олон улсын болон гадаад улсын байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр

Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт судалгаа хийхийг хориглоно.

11.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлага, стандартад нийцсэн байна.

### **2.19 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан**

1.Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сантай байна.

2.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүрэлдэхүүн нь хүүхдийн цахим хувийн хэрэг байна.

3.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг хэрэг бүрдүүлэх зарчим, хэлбэр нэгдмэл байна.

4.Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах, аюулгүй байдлыг хангах, ашиглах журмыг Засгийн газар батална.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ**

### **3.1 дүгээр зүйл.Гэр бүл дэх хүүхэд хамгаалал**

1.Эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалахдаа нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон хүчирхийллээс ангид хүмүүжлийн зэрэг арга хэрэглэж, хүүхдэд зөвлөн тусална.

2.Эцэг, эх хүүхдийнхээ эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.

3.Эцэг, эх хүүхдийнхээ амьдарч байгаа орчны эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг арилгах, гэр бүлийн хүрээнд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

4.Эцэг, эхэд хүүхэдтэй холбоотой эрхээ урвуулан ашиглах, зүй бус харьцах, бие махбодын шийтгэл хэрэглэх, доромжлон гутаахыг хориглоно.

5.Эцэг, эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх, хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээндээ ажиллуулахыг хориглоно.

6.Эцэг, эх хүүхдийнхээ эрх, нэр төрд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, дуудүрсний, дүрсний бичвэр, гэрэл зургийг бусдад дамжуулах, цахим орчинд байршуулахыг хориглоно.

7.Эцэг, эх нь энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хүсэлт гаргах, зөвлөгөө, мэдээлэл авах, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөс бусад тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээнд оролцох, хамтран ажиллах эрхтэй.

8.Эцэг, эх нь хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас зохион байгуулах хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын сургалтад хамрагдаж тодорхойлолт авсны үндсэн дээр Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.6, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан тэтгэмжид хамрагдана.

9.Энэ зүйл нь хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэгэн адил үйлчилнэ.

### **3.2 дугаар зүйл.Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал**

1.Боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллага, сүм, хийд, түүний дэргэдэх шашны сургууль нь боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

2.Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.1.хүүхдийг амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцуулахгүй байх;

2.2.хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах;

2.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах хайрцаг байрлуулах;

2.4.гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах;

2.5.хүүхдийг хорт зуршил, согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;

2.6.багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийн эрх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх талаар сургалтад хамруулах, зөвлөгөө өгөх;

2.7.сургалтын байгууллагын барилга байгууламжид зөвшөөрөгдсөн байршилд хуульд заасны дагуу хяналтын камер байршуулах, сургуулийн орчны замын хөдөлгөөнд хурд сааруулагч, аюулгүйн тэмдэг, тэмдэглэгээ хийлгүүлэх;

2.8.сургалтын орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

2.9.хүүхэд хоорондын болон хүүхэд ба эцэг, эх, багш, ажилчдын харилцааны зөрчил, хүүхдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

2.10.хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийн хүний хувийн болон эмзэг мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа этгээдэд мэдээлэх, задруулахгүй байх;

2.11.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, холбогдох харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад мэдэгдэх.

3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сургуулийн багш, ажилтан, сэтгэл зүйч, сайн дурын ажилтан нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн талаар мэдсэн, таамагласан бол тухайн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургуулийн нийгмийн ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

4.Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь энэ зүйлийн 3-т заасан мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж дараах арга хэмжээг авна:

4.1.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад мэдэгдэх, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байвал холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

4.2.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдээлсэн суралцагчийн мэдээллийн нууцыг хадгалах, цаашид хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

4.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй уулзалт зохион байгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

4.4.хохирогч хүүхдийг сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд нэн даруй хамруулах, удаа дараа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрснөөр өөр бүлэг, сургууль руу шилжүүлэх;

4.5.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн суралцагчийг сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах, дараах арга хэмжээг шат дараалан хэрэглэх:

4.5.1.суралцагчид өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;

4.5.2.суралцагчийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр, сургалтад хамруулах;

4.5.3.суралцагчийг байгууллагаас зохион байгуулж байгаа сайн үйл, нийтэд тустай ажил, арга хэмжээнд оролцуулах;

4.5.4.суралцагчийг өөр бүлэг рүү шилжүүлэх эсхүл харьяа дүүргийн боловсролын хэлтэс болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагатай хамтран өөр сургууль руу шилжүүлэх.

4.6. хяналт шалгалтын тайлан, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлангаа харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад тухай бүр хүргүүлэх;

4.7. хуульд заасан бусад арга хэмжээ авах.

5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1. боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг батлах;

5.2. боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

5.3. боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээг авах;

5.4. боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх;

5.5. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж, хяналт тавих;

5.6. боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөх стандартын ерөнхий шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.

6. Шашны байгууллага /сургууль/-ын дэргэдэх дотуур байранд байрлаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, аймгийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран хяналт тавина.

7. Гадаад улсад шашны байгууллага /сургууль/-д суралцаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.

8. Шашны байгууллага /сургууль/-д суралцах хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9. Боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллага, сүм, хийд, түүний дэргэдэх шашны сургуулийн багш, ажилтан нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, ашиг хохирсон бол холбогдох хуулийн хариуцлага хүлээнэ.

### **3.3 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал**

1. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

2.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй мэдээлнэ.

3.Эрүүл мэндийн байгууллага хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээг гэр бүлийн хүчирхийллийн болон гэмт хэргийн хохирогч хүүхдэд харьяалал, дараалал харгалзахгүйгээр шууд үзүүлнэ.

4.Эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа мэдсэн хүүхэд, түүний гэр бүлийн гишүүний хувийн болон эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан шаардсанаас бусад тохиолдолд бусдад дамжуулах, мэдээлэхийг хориглоно.

5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг батлах;

5.2.эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

5.3.эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авах;

5.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх;

5.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалт зохион байгуулах.

6.Эрүүл мэндийн байгууллага, ажилтан нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### **3.4 дүгээр зүйл.Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал**

1.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн орчинд, боловсролын сургалтын байгууллага сургалтын болон дотуур байрны орчинд, хуулийн этгээд хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хортой контент, бүтээлээс хамгаална.

2.Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ.

3.Цахим орчин болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх хориотой, хортой контент, бүтээлээс хамгаалах орон тооны бус дэд зөвлөл Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дэргэд ажиллана.

4.Энэ зүйлийн 3-т заасан орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд хүн, интернэтийн болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн төлөөллийг оролцуулах бөгөөд цахим орчин дахь хүүхэд хамгааллын салбар дундын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавина.

5.Хүүхэд, хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагч өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хүүхдэд зориулсан контент, бүтээл нь хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн, хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй, хүүхдийг цахимаар дарамталсан, дээрэлхсэн байж болзошгүй тохиолдлыг цагдаагийн байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хороонд гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

6.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хориотой, хортой контент, бүтээлийг таних, хязгаарлах, хаах арга хэмжээг авах үүрэгтэй.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хориотой, хортой контентыг хязгаарлах, контентын ангиллын тэмдэглэгээг олон нийтэд түгээхийн өмнө байршуулах, насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх боломжоор хэрэглэгчийг хангасан байна.

8.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч хүүхдийг гүтгэсэн, заналхийлсэн, хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн хувийн болон эмзэг мэдээлэл, зураг, дүрс, дуу авиа, хэн болохыг тогтоох боломжтой бусад мэдээллийг агуулсан контентыг бүтээх, түгээхийг хориглоно.

9.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг баталж, уг бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авна.

10.Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээг дэмжих, цахим орчинд хүүхдэд учрах нийтлэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.Хүн, хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

**3.5 дугаар зүйл.Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал**

1.Худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд хүлээнэ.

2.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулагч хууль, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл бүрдсэн, эсхүл хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

3.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хүн, хуулийн этгээд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд мэдэгдэх үүрэгтэй.

4.Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

5.Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээнд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага хяналт тавина.

6.Хүн, хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### **3.6 дугаар зүйл.Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал**

1.Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

2.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

3.Сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтран сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд, төрийн байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.

4.Соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээний үе болон бэлтгэлийн үед багш, дасгалжуулагч нь бэлтгэлийн үе болон уралдаан, тэмцээний үед амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэгтэй.

5.Хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах үүргийг хүлээнэ:

5.1.уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байх;

5.2.уралдаанч хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах;

5.3.уралдаанч хүүхдийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасны дагуу батлагдсан стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах;

5.4.уралдаанч хүүхдийг хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан ослын даатгалд даатгуулах;

5.5.уралдаанч хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирсан, амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл байдал бий болсон тохиолдолд хүүхдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн даруй хамруулах;

5.6.уралдаанч хүүхдийг нэг өдөр хоёроос дээш удаа хурдан морь унуулж уралдуулахгүй байх. Энэ заалт нь уралдааны бэлтгэл үе шатанд хамаарахгүй;

5.7.уралдаанч хүүхдийн эцэг, эх, харгалзан дэмжигчтэй хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, урамшуулал, бай, шагналыг тусгасан гэрээг бичгээр эсхүл хуульд нийцүүлэн цахим хэлбэрээр байгуулах.

6.Хурдан морины уралдаанд уралдах морийг унах хүүхдийн нас Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тогтоосон наснаас доогуур байж болохгүй.

7.Хурдан морины уралдаанд уралдах морийг унах хүүхдийг ослын даатгалд даатгуулсан эсэх болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хяналт тавина.

8.Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, хүүхдийн эрхийг хамгаалах журмыг соёлын, биеийн тамир, спортын болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж, мөрдүүлнэ.

9.Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгааллын бодлогыг соёлын асуудал эрхэлсэн болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, уг бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авна.

10.Хүн, хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### **3.7 дугаар зүйл.Гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд хамгаалал**

1.Төрийн бүх байгууллага, албан тушаалтанд гамшиг, онцгой байдлын нөхцөлийн ямар ч үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хязгаарлах, зогсоох шийдвэр гаргахыг хориглоно.

2.Гамшиг, онцгой байдлын нөхцөлийн үед хүүхэд хамгааллын үйлчилгээг боломжит бүхий л арга, хэлбэрээр хүргэхэд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан туслалцаа үзүүлнэ.

3.Гамшиг, онцгой байдлын нөхцөлийн үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай үзүүлэх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд, сайн дурын ажилтны оролцоотойгоор зохион байгуулна.

4.Гамшиг, онцгой байдлын нөхцөлийн үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд тоон гарын үсэг, цахим тамга, цахим баримт бичиг, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ ашиглаж болно.

5.Гамшиг, онцгой байдлын нөхцөлийн үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

6.Гамшигийн үеийн хүүхэд хамгааллын бодлогыг гамшигийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, уг бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авна.

7.Хүн, хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

### **3.8 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал**

1.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 7 нас хүрсэн хүүхдийн үг хэлэх, саналаа илэрхийлэх эрхийг нь заавал хангана.

2.Хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах, хүүхдийн биед үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон таатай орчинд гүйцэтгэх ба уг ажиллагааг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг байлцуулахгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

3.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх нь хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авахын өмнө дараах ажиллагааг гүйцэтгэсэн байна:

3.1.хүүхэд өөрийн санал, шийдвэрээ гаргахад нь шаардлагатай мэдээллийг өгөх;

3.2.өөрийнх нь хүсэл зориг, өөрийнх нь дэмжсэн санал, хэлсэн үг, шийдвэрээс нь гарч болох үр дагаврыг тайлбарлах.

4.Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр, хүүхэд 14 нас хүрсэн бол түүний зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдэгдэхийг хориглоно.

5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

7.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **4.1 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр**

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна:

- 1.1.шуурхай тусламжийн үйлчилгээ;
- 1.2.хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ;
- 1.3.урьдчилан сэргийлэх үйлчилгээ.

2.Энэ хуулиар зохицуулаагүй хүүхэд хамгааллын үйлчилгээний бусад харилцааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

### **4.2 дугаар зүйл.Шуурхай тусламжийн үйлчилгээ**

1.Энэ хуулийн 4.11 дүгээр зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, өөрөө илрүүлсэн сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн алба хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд аюултай нөхцөлд байдалд орсон бол хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлж аюулыг зайлуулах, аюул учруулах нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг нэн даруй авна. Шаардлагатай гэж үзвэл хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийнх нь зөвшөөрөлгүйгээр аюултай нөхцөл байдал арилах хүртэл аюулгүй газар түр байрлуулж болно.

2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.3-д заасан арга хэмжээний аль нэгийг авч, хүүхдийг гэр бүлээс нь түр хугацаагаар тусгаарлах арга хэмжээг авна. Энэ тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамгаалагчийн зөвшөөрлийг шаардахгүй.

3.Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг нэн даруй холбон зуучилна. Шаардлагатай тохиолдолд хүүхдийг хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд ороогүй бол хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэн өгнө.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон” гэж хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн, хүүхдийн зан байдал нь өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулахаар нөхцөл байдалд байгааг ойлгоно.

#### **4.3 дугаар зүйл.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ**

1.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ гэр бүлийн орчинд болон гэр бүлээс нь тусдаа орчинд гэсэн хэлбэрээр үзүүлнэ.

2.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хүрээнд дараах үйлчилгээг үзүүлнэ:

2.1.хүүхдийг асрах, өсгөж хүмүүжүүлэх талаарх зөвлөгөө, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх;

2.2.сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх;

2.3.хүүхдийн эсрэг хүчирхийллээс улбаатай хүүхдийн зан авирын өөрчлөлтөд чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

2.4.хүүхдийг суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн онцлог, хөгжлийн түвшинд тохирсон хөгжлийн, амьдрах ухааны сургалт, үйл ажиллагаанд хамруулах, тохиромжтой үйл ажиллагаанд холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх;

2.5.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх;

2.6.сургууль завсардсан хүүхдийн чадвар, бэрхшээлийн онцлог, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх;

2.7.хүүхэд, эцэг, эхийн харилцааг сайжруулах, харилцааны зөрчил, хямралыг шийдвэрлэх сургалтад хамруулах;

2.8.хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын хүрээнд хөнгөн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, аюултай, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх;

2.9.амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор гэр бүлд тусламж, дэмжлэг үзүүлэх, ажлын байранд холбон зуучлах;

2.10.нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэхэд нь туслалцаа үзүүлэх;

2.11.архи, согтууруулах ундаа, мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хамааралтай эцэг, эх, асран хамгаалагчтай ажиллах тусгай хөтөлбөр гаргаж, үйлчилгээнд хамруулах;

2.12.хүчирхийллийн харилцаатай эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын хөтөлбөрт хамруулах;

2.13.хүүхэд үрчилж авсан эцэг, эхэд эцэг, эхийн үүрэг, хариуцлага хүлээх, үрчлэх үйл ажиллагааг дуусгавар болгох, үрчлэлтийг цуцалсан тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд туслалцаа үзүүлэх;

2.14.гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ үзүүлэх;

2.15.хууль тогтоомж, стандартад заасан бусад.

3.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг энэ хуулийн 4.13 дугаар зүйлийн 3-т заасан хүүхэд хамгаалах үйлчилгээний төлөвлөгөөний дагуу үзүүлнэ.

4.Энэ зүйлийн 2-т заасан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг нэгэн зэрэг хослуулан үзүүлж болно.

5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон 18-аас дээш 21 хүртэл насны хүн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд түүнд 21 нас хүртэл нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж болно.

6.Сэтгэл зүйн үйлчилгээний стандарт, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

#### **4.4 дүгээр зүйл.Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх**

1.Гэр бүлийн орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үр дүнд хүрээгүй эсхүл уг үйлчилгээг гэр бүлийн орчинд үзүүлэх нь хүүхдийн эрхэд хор хохирол учруулахаар байгаа тохиолдолд гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.

2.Гэр бүлээс тусдаа орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ дараах хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг ашиглана:

2.1.хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах;

2.2.хүүхдийг асралт гэр бүлд асруулах;

2.3.асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах.

3.Хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах, үйлчилгээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэхдээ 7 нас хүрсэн хүүхдийн санал, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны дүгнэлтийг авна.

4.Сум, дүүргийн Засаг дарга эсхүл хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд

хамруулах хүртэл хугацаанд хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах арга хэмжээг урьдчилан авч болно.

5.Хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахдаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдөхөөс бусад тохиолдолд хүүхдийг ах, эгч, дүүтэй нь хамт байлгана.

6.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

8.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний явцад сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хяналт тавина.

#### **4.5 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэл**

1.Дараах үндэслэлээр хүүхдэд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ:

1.1.эцэг, эх нь хоёулаа нас барсан;

1.2.эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;

1.3.эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон;

1.4.шүүхээс эцэг, эх байх эрхийг нь хязгаарласан, хассан;

1.5.эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, цагдан хоригдсон, хорих ял эдэлж байгаа зэрэг шалтгаанаар хүүхдээ биечлэн асран хамгаалах, тэжээн тэтгэх боломжгүй болсон;

1.6.эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдээ хамгаалах, асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх үүргээ удаа дараа биелүүлээгүй;

1.7.эцэг, эх нь хүүхдийнхээ эсрэг хүчирхийлэл үйлдсэний улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, хөгжилд эрсдэл учирсан.

2.Гэрлэлт цуцлуулсан болон хуульд заасан бусад үндэслэлээр хүүхдийн асрамждаа авсан эцэг /эх/-ийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.7-д заасан үндэслэл бий болсон нь хүүхдэд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхэд нэгэн адил үйлчилнэ.

3.Хүүхдийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1.5, 1.6, 1.7-д заасан үндэслэлээр гэр бүлээс нь тусгаарлаж, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулсан бөгөөд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх боломжгүй тохиолдолд эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах асуудлыг Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

4. Энэ зүйлд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдаж, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хөрөнгө, өвлөгдөх хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоож, хяналт тавих асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### **4.6 дугаар зүйл. Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах**

1. Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах эсэхийг тухайн гэр бүлээс бичгээр зөвшөөрөл авч, гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

2. Хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулахаар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохтой холбоотой бусад харилцааг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулна.

#### **4.7 дугаар зүйл. Хүүхдийг асралт гэр бүлд асруулах**

1. Асралт гэр бүл болох хүсэлт гаргасан хүний гэр бүлийн мэдээллийг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага бүртгэн авч, тухайн гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийнэ. Нөхцөл байдлын үнэлгээгээр тухайн гэр бүл асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой нь тогтоогдсон тохиолдолд сургалтад хамруулж, гэрчилгээ олгоно.

2. Хүүхдийг асралт гэр бүлд асруулахаар шилжүүлэхдээ тухайн гэр бүлтэй орон нутгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээг байгуулна.

3. Хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээнд дараах зүйлийг тусгана:

3.1. хүүхдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох нөхцөлөөр хангах;

3.2. асран хүмүүжүүлэгчийн эрх, үүрэг;

3.3. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын эрх, үүрэг;

3.4. асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад тэтгэмж, хөнгөлөлт;

3.5. асран хамгаалуулагчийн эд хөрөнгө;

3.6. гэрээний хугацаа, гэрээ цуцлагдах, дуусгавар болох үндэслэл, түүний үр дагавар.

4. Эд хөрөнгө, санхүү, эрүүл мэндийн байдлын хувьд хүүхдийг асран хүмүүжүүлэх боломжгүй, асран хүмүүжүүлж байсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, Гэр бүлийн тухай хуульд заасан асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хориглосон хүнтэй хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хориглоно.

5. Хүүхдийг асралт гэр бүлд шилжүүлсний дараа тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл бий болсон, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан, хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болохгүй хүн болох нь хожим илэрсэн, бий болсон бол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал

эрхэлсэн орон нутгийн байгууллага болон сум, дүүргийн Засаг дарга гэрээг нэн даруй цуцалж, хүүхдийг буцаан авна.

6.Асралт гэр бүл хүндэтгэн үзэх шалтгаан /өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ бий болсон бол гэрээг хугацаанаас өмнө цуцалж, хүүхдийг буцаан өгч болно.

7.Асралт гэр бүлд шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах болон хууль тогтоомжийн дагуу бусад хангамжаар хангагдах эрх эдэлнэ.

#### **4.8 дугаар зүйл.Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах**

1.Хүүхдийг энэ хуулийн 4.6, 4.7 дугаар зүйлд заасан үйлчилгээнд хамруулах боломжгүй тохиолдолд хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулна.

2.Хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээг гэр бүлтэй дүйцэхүйц орчинд болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж хүргэнэ.

3.Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулахтай холбоотой бусад харилцааг Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулна.

#### **4.9 дүгээр зүйл.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан кейс менежмент, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлж, үр дүнг үнэлнэ.

2.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 2.1.зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;
- 2.2.олон талт, хамтарсан арга хэмжээ.

3.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь төрийн захиргааны болон нутгийн захиргааны, шүүх эрх мэдэл болон хууль сахиулах, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай уялдсан байна.

4.Хуулийн этгээд бүр хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах үүрэгтэй.

5.Урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайн дурын ажилтны болон хүүхдийн оролцоо, тусламжтайгаар зохион байгуулж болох ба уг ажилтныг бүртгэх, сургах ажлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага зохион байгуулна.

6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй харилцах соён гэгээрүүлэх чиглэлийн стратегийг боловсруулж батална.

## I дэд бүлэг Кейс менежмент

### 4.10 дугаар зүйл. Кейс менежментийн үе шат

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээг кейс менежментийн дараах үе шатны хүрээнд үзүүлнэ:

- 1.1. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, харилцаа холбоо тогтоох;
- 1.2. хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх;
- 1.3. хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргах;
- 1.4. хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, зохицуулах;
- 1.5. хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх;
- 1.6. хүүхэд хамгааллын кейсийг хаах.

2. Урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхэд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан кейс менежментийн үе шат хамаарахгүй.

3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна.

4. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын кейсийг нээхээс хаах хүртэлх хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд хийгдсэн бүх шийдвэр, үйл ажиллагааг холбогдох стандарт, маягт, зааврын дагуу заасан хугацаанд баримтжуулж, биет болон цахим хэлбэрээр хадгалж, мэдээллийн санд оруулна.

5. Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдийн тухайн оршин байгаа газрын хамтарсан баг, хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага үзүүлнэ. Хүүхэд хамгааллын кейсийг шийдвэрлэх явцад хүүхдийн оршин байгаа газар өөрчлөгдсөн тохиолдолд хүүхэд хамгааллын кейсийг харьяаллын дагуу хамтарсан баг, хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага руу шилжүүлнэ.

6. Шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхээр бүртгэсэн хүүхэд, түүний гэр бүлийг хүүхэд хамгааллын нэг кейс гэж үзэх бөгөөд кейс тус бүр бүртгэл, дугаартай байна.

7. Энэ дэд бүлгээр зохицуулаагүй бусад харилцааг бусад холбогдох хууль, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталсан нийгмийн ажлын үйлчилгээний стандартаар зохицуулна.

### 4.11 дүгээр зүйл. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сум, баг, хорооны Засаг дарга өөрийн санаачилгаар, хүүхэд болон бусад хүн, хуулийн этгээдээс гомдол, мэдээлэл хүлээн авах зэрэг боломжит бүхий л аргыг ашиглана.

2.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн эрх зүйн чадамжтай хүн энэ талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сум, баг, хорооны Засаг дарга, хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

3.Ажил, мэргэжлийн үйл ажиллагааныхаа хүрээнд болон сайн дурын үйл ажиллагааны явцад хүүхэдтэй шууд харилцаж байгаа хүн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх үүрэг нь түүний хууль, ёс зүйн дүрэм, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээс давуу үйлчилнэ.

4.Энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулна.

#### **4.12 дугаар зүйл.Мэдээлэл өгөгчийг нууцлах**

1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээд нь өөрийнхөө тухай мэдээллийг бусад этгээдэд задруулах зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд уг этгээдийн хувийн мэдээллийг нууцална.

2.Хүүхэд өөрөө тусламж авахаар хандсан тухай хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй тохиолдолд мэдээллийг нууцална.

3.Энэ зүйлд заасан мэдээллийг нууцлахад мэдээллийн эх сурвалж, мэдээлэл өгөгчийн хувийн мэдээллийг хамгаалах, бусдад задруулахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

#### **4.13 дугаар зүйл.Нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө гаргах**

1.Хүүхдэд тохирох хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ шаардлагатай тохиолдолд хамтарсан баг эсхүл холбогдох мэргэжилтний туслалцааг авч болно.

2.Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, зан авир, танин мэдэхүй, нийгэмшихүй, боловсролын байдал, гэр бүл, сургалтын орчин, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд өсгөх ур чадвар, тэдний хоорондын харилцаа зэрэг нөхцөл байдлыг нягтлан судална.

3.Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь тогтоогдсон бол хүүхэд, түүний гэр бүлийн орчин, нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргана.

4.Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, оролцогч талуудын хамтын ажиллагаа, тэдгээрийн ажил, үүргийн хуваарилалт, харилцан мэдээлэл солилцох журам, алслагдмал газар, засаг захиргааны нэгжид оршин суудаг хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх зэрэг асуудлыг тусгана.

5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг хамтарсан багийн ахлагч болон төлөвлөгөөг боловсруулсан этгээд баталгаажуулах ба шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахад хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, долоон нас хүрсэн хүүхдийн саналыг авна.

7. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг харьяа хууль зүйн хорооны ажлын албанд хүргүүлнэ.

8. Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу урамшуулал олгоно.

#### **4.14 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, зохицуулах**

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээг энэ хуулийн 4.13 дугаар зүйлийн 3-т заасан төлөвлөгөөний дагуу үзүүлнэ.

2. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтарсан багийн гишүүд, оролцогч бусад талуудын санал, дүгнэлтийг авах, тэдэнтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, зөвлөгөөн хийх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулж ажиллана.

#### **4.15 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх**

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг явцын болон эцсийн үнэлгээг хийнэ. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг авч үнэлгээнд тусгана.

#### **4.16 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын кейсийг хаах**

1. Хүүхэд хамгааллын кейсийг дараах үндэслэлээр хаана:

1.1. хүүхэд хамгааллын үйлчилгээний зорилго биелэгдэж, хүүхдийн сайн сайхан байдал хангагдсан;

1.2. хүүхэд 18 насанд хүрсэн бөгөөд хүүхэд 21 нас хүртлээ хүүхэд хамгааллын үйлчилгээ авахыг зөвшөөрөөгүй;

1.3. хүүхэд үрчлэгдсэн;

1.4. хүүхэд нас барсан.

2.Хүүхэд хамгааллын кейсийг хаахад харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад танилцуулж, зөвшөөрөл авна.

3.Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан улирал тутам нөхцөл байдлын үнэлгээ хийж, хоёр жил хүртэл хугацаанд хяналт тавина.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА**

### **5.1 дүгээр зүйл.Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага, түүний хэлбэр**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагаар хангах (цаашид “мэргэжлийн удирдлага” гэх) үүргийг хэрэгжүүлнэ.

2.Мэргэжлийн удирдлагыг хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн нэгдсэн зохион байгуулалтын болон хүүхэд хамгааллын тодорхой кейстэй холбоотойгоор удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, зааврыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **5.2 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлагын хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох;

1.2.хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарч буй алдаа дутагдал, бэрхшээлийг тухай бүр тодорхойлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор нэгдсэн зөвлөмж, аргачлал, зааврыг боловсруулж, мөрдүүлэх;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, хүүхэд хамгааллын кейсээс түүвэрлэн хянаж, нийтлэг гарч байгаа алдаа, дутагдлыг тогтоож, зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах;

1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас доод шатны албан хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг шалгаж, биелэлтийг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл, зааварчилгаа өгөх;

1.5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын албан хаагч, хүүхэд, гэр бүлийн болон бусад салбарын нийгмийн ажилтантай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, зөвлөмж, зөвлөгөө өгөх;

1.6.хүүхэд, гэр бүлийн болон бусад салбарын нийгмийн ажилтныг сургах, давтан мэргэшүүлэх, ажлын байран дээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулах.

### **5.3 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.тухайн орон нутгийн хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

1.2.хүүхэд хамгааллын кейс бүрийн материалтай танилцаж, алдаа, дутагдлыг арилгах арга хэмжээ авах, энэ талаар илтгэх хуудаст тусгах;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хийгдэж байгаа ажиллагаа, баримтжуулалтад хяналт тавих;

1.4.хүүхэд хамгааллын кейсийн статистик мэдээ, кейс шийдвэрлэлтэд үндэслэн хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдэд зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах;

1.5.хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлаар ярилцлага хийх, чиглэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

1.6.арав хүртэлх нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг ахлах нийгмийн ажилтан, тав хүртэлх ахлах нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нэг зөвлөх нийгмийн ажилтан ажиллахаар тооцож зохион байгуулалт хийх.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТ БА ХЯНАЛТ**

### **6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт**

1.Хүүхэд хамгааллыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 1.1.улсын төсөв;
- 1.2.орон нутгийн төсөв;
- 1.3.үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр;

1.4.дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж.

2.Хүүхэд хамгааллын санхүүжилтийг энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтооно.

4.Төр хүүхэд хамгааллын асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлж чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

5.Хүүхэд хамгаалалд тусгагдсан төсвийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан баг болон гэрээгээр хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

6.Хуулийн этгээд нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.

7.Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар батална.

## **6.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хяналт-шинжилгээ, үнэлгээ**

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор дараах хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

1.1.орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг авч нэгтгэн дүгнэх;

1.2.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;

1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар бүртгэл, судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийх;

1.4.хүүхэд хамгаалалд хүн, хуулийн этгээдийн оролцоог үнэлэх;

1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;

1.6.энэ хууль, хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг өөрөө эсхүл бусад мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх.

### **6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт**

1.Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөөр удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан энэ хууль болон бусад холбогдох хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

### **6.4 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын захиргааны хяналт**

1.Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид тавих захиргааны хяналтыг хүүхдийн эрхийн улсын байцаагч гүйцэтгэнэ.

2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлсэн, мэдээлэл авсан бол энэ талаар харьяа хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд тухай бүр мэдэгдэх;

1.2.хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгах явцад хүүхэд аюултай нөхцөлд байдалд орсон нөхцөл байдал бий болсон бол хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах;

1.3.нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байранд байгаа болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан, үрчлэгдсэн хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих;

1.4.хүн, хуулийн этгээдээс хүүхэд хамгааллын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах;

1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хүн, хуулийн этгээд гэрээний үүргээ удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон бол түүнтэй байгуулсан гэрээг цуцлах санал гаргах, магадлан итгэмжлэлийг хүчингүй болгуулах, эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах тухай саналыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

1.6.хүүхдийн эрхийг зөрчсөн, хүүхэд хамгааллын асуудлаар энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа албан хаагч, ажилтныг ажлаас чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулан тухай саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

1.7.хууль тогтоомжид заасан бусад.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **7.1. дүгээр зүйл. Гомдол, нэхэмжлэл гаргах**

1.Энэ хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын асуудлаар гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчсөн гэж үзвэл Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу гомдол, нэхэмжлэл гаргаж болно.

### **7.2 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **7.3 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

1.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө томилогдон ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн асуудал нийгмийн ажилтан нь энэ хуулийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан дээд боловсролын шаардлага хангахгүй байгаа тухайн ажилтныг нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамруулсны үндсэн дээр хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хэвээр ажиллуулна.

2.Энэ хуулийн 2.7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу тогтоосон орон тоогоор сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулна.

### **7.4 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

1.Энэ хуулийг 2023 оны ..... дүгээр сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг